



Хаяг: Konrad-Adenauer-Stiftung
Монгол дахь Суурин
төлөөлөгчийн газар
Сөүлийн Гудамж,
Браухаус – 22
Улаанбаатар 210628

Утас: +976 11 31 91 35 oder -136

Факс: +9 76 11 31 91 37
info.mongolia@kas.de



Хаяг: СЭЗДС-ийн хичээлийн С
корпус, С-1105 тоот өрөө,
Энхтайвны өргөн чөлөө 5,
113381 Улаанбаатар

Утас: 7000 8084, 99105111,
88978179

Факс: 7000 8084
E-mail: info@cgdc.org.mn



КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА БА ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД – ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛҮҮД БА ХЭТИЙН ЧИГ ХАНДЛАГА

Судалгааг Монголын Компанийн Засаглалын Хөгжлийн Төвөөс бэлтгэв





КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА БА ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД- ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛҮҮД БА ХЭТИЙН ЧИГ ХАНДЛАГА

Судалгааг Монголын Компанийн Засаглалын Хөгжлийн Төвөөс бэлтгэв

Улаанбаатар
2017, 6-р сар

ГАРЧИГ

| | |
|--|-----------|
| Оршил..... | 4 |
| Судалгааны арга зүй..... | 5 |
| 1.Компанийн Нийгмийн Хариуцлага (КНХ) – Олон янзын тодорхойлолтууд, тэдгээрийн үндсэн утга агуулга..... | 6 |
| 1.1. КНХ–ыг хэрхэн тодорхойлдог болох нь..... | 6 |
| 1.2. Амжилттай КНХ–ын үр ашиг ба суурь нөхцөлүүдийг тайлбарлах нь..... | 7 |
| Байгаль орчин, нийгмийн ба засгийн газрын хөтөлбөрүүдийн компанийн санхүүгийн гүйцэтгэлд үзүүлэх нөлөө..... | 8 |
| Хөгжиж буй орнууд ба шинээр гарч ирж буй зах зээлүүд дэх КНХ..... | 10 |
| Хэрэглэгчид ба иргэд олон нийт чиглүүлэгч хүч болох нь..... | 10 |
| Хамаарагч талуудын харилцаа чухал байр суурьтай болж байна..... | 11 |
| Компанийн зүгээс КНХ–д гарч буй саад бэрхшээлүүд..... | 12 |
| 1.3. Дүгнэх нь: Итгэлцэл, ил тод байдал, яриа хэлэлцээ ба харилцан ойлголцолын үүрэг..... | 13 |
| 2. КНХ–аас Тогтвортой Хөгжлийн Зорилтуудад хүрэх нь (ТХЗ)..... | 14 |
| 2.1.ТХЗ–ууд нь хариуцлагатай бизнесийг бий болгоход ерөнхий хүрээ, чиг шугам болох нь..... | 14 |
| Бизнесүүдэд гарах үр өгөөж ба тэдний үүргийг НҮБ–ийн байр суурьнаас авч үзсэн нь..... | 15 |
| 2.2. Компаниудын хүлээлт ба үүрэг – Дэлхий нийтийн (Бизнесийн) өнцгөөс авч үзэх нь..... | 16 |
| Гүйцэтгэл одоогоор хязгаарлагдмал байгаа нь..... | 17 |
| Ирээдүйн бэрхшээлүүд – Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох болон хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэлийн зорилтууд дээр ахиц маш удаан байгааг экспертүүд онцолж байна..... | 17 |
| ТХЗ–уудад үүрэг хүлээх нь компаниудад дэлхий нийтээр бизнест итгэх итгэл буурч байгаагийн эсрэг алхам хийх боломж болох нь..... | 18 |
| 3. Монголын нөхцөлд хийх дүгнэлт ба авсан сургамж – Хамаарагч талуудын идэвхтэй оролцоо ба хоорондын яриа ойлголцол амжилтын гол хүчин зүйл болох нь..... | 20 |
| 4. Монголын компаниудын ойлголтуудын тухай судалгаа – ТХЗ–ууд нь тогтвортой хөгжил ба компанийн амжилтыг нэгтгэх боломж болох нь..... | 22 |
| 4.1. Компанийн Нийгмийн Хариуцлага – Танил хандлага үл итгэх хандлага хоёр уулзсан нь..... | 22 |
| 4.1.1. КНХ /хариуцлагатай бизнесийг тодорхойлох нь..... | 22 |
| 4.1.2. КНХ /хариуцлагатай бизнесийн ач холбогдол..... | 24 |
| 4.1.3. Компанийн өнцгөөс Монгол дахь КНХ–ын түвшинг тодорхойлох нь..... | 24 |
| 4.1.4. Хэн КНХ–ыг хэрэгжүүлэх ёстой вэ, хэн үр өгөөжийг нь хүртэх вэ?..... | 27 |
| 4.1.5. Компанийн түвшинд хариуцлагатай бизнесийг удирдах нь –Бодлого ба хэрэгжүүлэлт..... | 28 |
| 4.1.6. Компаниуд болон хамаарагч талууд..... | 30 |
| Бага хэмжээний үүрэг ажилчдад хамаарч байна..... | 31 |
| 4.2. Тогтвортой Хөгжлийн Зорилтууд – Бүх хамаарагч талуудын оролцоог шаардсан хариуцлагатай бизнесийг дэмжих Монгол дахь шинэ хүч..... | 31 |
| 4.2.1. Монгол улсад тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад компаниудын гүйцэтгэх үүрэг..... | 32 |
| 4.2.2. ТХЗ–уудад хувь нэмрээ оруулахад компаниудад юу сэдэл болох вэ..... | 36 |
| 4.2.3. ТХЗ–ууд тус бүр Монгол улсад гүйцэтгэх ач холбогдол болон компаниудийн гүйцэтгэх үүрэг – Яагаад, Хэрхэн..... | 37 |
| 4.3. Хамтын ажиллагаа, мэдлэг хуваалцах нь Тогтвортой Монгол (бизнес) –ийн ирээдүй..... | 41 |
| 4.4. Судалгаа – ТББ–уудын байр суурь..... | 43 |
| 4.5. Судалгаа – Бизнесийн Холбоодын байр суурь..... | 44 |
| 4.6. Дүгнэлт..... | 46 |
| Нэгтгэл ба Зөвлөмжүүд..... | 46 |
| ХАВСРАЛТ..... | 48 |
| А. Ярилцлаганд оролцсон компаниудын жагсаалт..... | 48 |
| В. Ярилцлаганд оролцсон Бизнесийн Холбоодын жагсаалт..... | 50 |
| С. Ярилцлаганд оролцсон ТББ–уудын жагсаалт..... | 51 |

ОРШИЛ

Энэхүү судалгааг Конрад Аденауэрын Сангийн өмнөөс Монголын Компанийн Засаглалын Хөгжлийн Төв (CGDC) хийсэн юм. Судалгаа нь Монголд Компанийн Нийгмийн Хариуцлага (КНХ)/хариуцлагатай/тогтвортой бизнесийн хөгжлийн төлөв байдлын одоогийн түвшнийг тодорхойлохоос гадна Тогтвортой Хөгжлийн Зорилтуудад (ТХЗ, мөн Дэлхийн Зорилтууд гэж нэрлэдэг) Монголын компаниудын оруулах боломжтой ирээдүйн хувь нэмэр, оролцоог тодорхойлох зорилготой юм. Судалгаа нь бизнесийн төлөв байдал болон ирээдүйд төвлөрсөн бөгөөд ингэхдээ тогтвортой амжиргааны тухай үзэл санааг түгээхэд чухал үүрэг бүхий хамаарагч талуудыг онцгойлон авч үзсэн юм. Үр дүнд нь улс төр, төрийн засаг захиргаа, бизнесүүд болон нийгмийн байгууллагуудад илүү мэдлэг мэдээлэл түгэх, тэдгээр хоорондоо тогтвортой хөгжил, тэр дундаа тогтвортой бизнесийн ирээдүй, боломж ба бэрхшээлүүдийг шийдэхэд хамтран ажиллах, үр дүнтэй мэдээлэл солилцоход ихээхэн тустай байх юм. Мөн энэхүү судалгаа нь хариуцлагатай нэгдмэл сонирхол, үүрэг хариуцлагууд дээр суурилсан тогтвортой нийгэм ба амьжиргааны сайн сайхан байдлыг бий болгож чадах эдийн засгийн системийн үр өгөөж, ач холбогдлыг хамаарагч талууд илүү сайн ойлгож хүлээж авахад тус нэмэртэй гэж үзэж байна. Судалгаанаас харагдсан үр дүнгүүд:

- ◆ Дэлхий нийтээр хариуцлагатай бизнес компанид ямар үр өгөөж авчирдаг болон КНХ нь “үр дүнгээ” өгдөг болохыг хэзээ хэзээнээс илүүтэйгээр хүлээн зөвшөөрдөг болоод байна. Илүү олон компаниуд өөрийн улсдаа болон дэлхий нийтийн хэмжээнд ТХЗ–уудыг хангахад хувь нэмрээ оруулахыг хүсэх болсон боловч ТХЗ–уудын өдөр тутмын бизнест үзүүлэх нөлөөллүүд дээр чиглэл, зөвлөмжүүд шаардагдсаар байна. Улс төрийнхэн, олон нийт ба хэрэглэгчдийн зүгээс тэдний зүтгэлийг үнэлэн дэмжих, хөхүүлэн сайшаах нь компаниудын зүгээс идэвх зүтгэлээ гарган хариуцлагатай, тогтвортой бизнесүүдэд илүүтэй хөрөнгө оруулахад чухал үүрэгтэй болж байна. Компани дотор болон түүнээс гадуур харилцаа холбоо бий болгох, харилцан ярилцах болон санал солилцох нь итгэлцлийг бий болгох үндсэн нөхцөл бөгөөд бүгдэд нь харилцан үр өгөөжтэй шийдлүүдийг гаргахад нэн чухал юм.

- ◆ Монголд компаниуд КНХ/хариуцлагатай/тогтвортой бизнес гэдэг нь ерөнхийдөө юу болох, өөрсдийн бизнестэй нь хэрхэн уялддаг болохыг ерөнхий, тойм байдлаар ойлгож байна. Ийм төрлийн арга хэмжээ, ажиллагаануудыг хэрэгжүүлэн удирдах явц хөгжлийнхөө дөнгөж эхний түвшиндээ явж байгаа бөгөөд компанийн төлөөлөгчдийн үзэж буйгаар улс төр, засаг захиргаа, хэрэглэгчид ба олон нийтийн зүгээс санхүүгийн болоод санхүүгийн бус дэмжлэгүүд илүү шаардлагатай байгаа юм. Компаниуд ТХЗ–уудын тухай хязгаарлагдмал ойлголттой байгаа бөгөөд ТХЗ хангахад оролцох шалтгаан, эндээс бий болох өргөн боломжуудыг хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч өөрсдийн зүтгэл, оролцоог бодитоор үнэлүүлэхийг хүсч байна.

- ◆ Дэлхий нийтийн хандлагатай харьцуулахад Монголын бизнесүүдийн хувьд бизнес болон улс төрийн хамтын ажиллагаа, харилцан ойлголцол, итгэлцэл бий болгох шаардлага өндөр байгааг хүлээн зөвшөөрч байна. Гэхдээ тогтвортой бизнесийн талбарт голлон оролцогч байх бус харин үүрэг, зорилтуудыг ажилчдынхаа түвшинд хэрэгжүүлэх хэмжээнд оролцох сонирхол Монгол компаниудад ажиглагдаж байна.

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА (КНХ) ОЛОН ЯНЗЫН ТОДОРХОЙЛОЛТУУД, ТЭДГЭЭРИЙН ҮНДСЭН УТГА АГУУЛГА

1.1. КНХ-ЫГ ХЭРХЭН ТОДОРХОЙЛОДОГ БОЛОХ НЬ

Компанийн соёл болон улс орон бүрийн зах зээлийн нөхцөл байдлуудаас хамаарч КНХ-ыг олон хэлбэрээр тодорхойлсон байна. Ерөнхийдөө энэ нь компани өөрийн үйл ажиллагаагаа “гурван суурь үзүүлэлтүүд” буюу эдийн засаг, байгаль орчин ба нийгэм олон нийтийн орчинд тогтвортой байдлаар нөлөөлөх тэр хэмжээнд удирдан хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг хэлнэ. Гэхдээ 3 суурь үзүүлэлт болон КНХ-ийг ТХЗ-ууд дээр тусгасан тогтвортой байдлын ойлголтуудтай уялдуулан авч үзэх нь ихээхэн маргаантай асуудал хэвээр байгаа.¹

КНХ ерөнхийдөө юу болох нь дараах нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн 2 тодорхойлолтоос харагдах боломжтой. Үүнд:

Европын Холбооноос тодорхойлсноор КНХ нь “Нийгмийн болон байгаль орчны асуудлуудыг өөрсдийн үйл ажиллагаа болон хамаарагч талуудтай харилцах харилцаандаа уялдуулахад компаниудад дэмжлэг болох зорилготой үндсэн суурь ойлголт” юм.² Европын Холбооны ойлголтоор КНХ нь “ЕХ-ны компаниуд болон ЕХ-ны эдийн засагт тогтвортой байдал, өрсөлдөх чадвар ба шинэ санаачлагуудыг бий болгоход чухал үүрэгтэй бөгөөд эрсдлийн удирдлага, зардал хэмнэлт,

хөрөнгө оруулалтыг татах, хэрэглэгчидтэй харьцах болон хүний нөөцийн удирдлагад үр өгөөж, ач холбогдолтой юм”. Үүнээс гадна КНХ нь “харилцан уялдаа бүхий нийгмийг байгуулан тогтвортой эдийн засгийн систем рүү шилжихэд суурь болох бүлэг үнэт зүйлсүүдийг” илэрхийлэх ач холбогдолтой гэсэн байна.

Үүнтэй төстэй байдлаар Эдийн Засгийн хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Байгууллага (ЭЗХАХБ) нь КНХ-ын тодорхойлолтыг цааш ахиулан, хариуцлагатай бизнес нь ажлын байр бий болгох, ур чадваруудыг нэмэгдүүлэх, технологийг хөгжүүлэх болон баялгийг хуваарилах замаар амжиргааны түвшинг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй болохыг онцолсон байна. “Хариуцлагатай бизнесийн зарчим, стандартууд нь байгаль орчны болон нийгмийн асуудлуудыг өөрийн үндсэн бизнесийн үйл ажиллагаанууддаа уялдуулахад төвлөрсөн байдаг”.³ ЭЗХАХБ цааш онцлохдоо “хуулийн статус, хэмжээ ба эзэмшлээс үл хамааран бүх бизнесүүд өөрсдийн үйл ажиллагаагаа явуулж байгаа улс орны эдийн засаг, байгаль орчин ба нийгмийн хөгжил дэвшилд эерэг хувь нэмэр оруулах ёстой бөгөөд үүний зэрэгцээ бүхий л бизнесийн хэлхээ, харилцан ажиллагаануудынхаа дагуу өөрсдийн үзүүлж болох сөрөг нөлөөллүүдээс зайлсхийх, эсвэл сөрөг нөлөөллүүдээ арилгах

¹ <https://sustainabledevelopment.un.org/?menu=1300>.


² https://ec.europa.eu/growth/industry/corporate-social-responsibility_en.

³ OECD, Development Co-operation Report 2016, <http://www.oecd-ilibrary.org/sites/dcr-2016-en/03/05/index.html;jsessionid=t5cidp1p9ogw.x-oecd-live-02?contentType=%2fns%2fChapter&itemId=%2fcontent%2fchapter%2fdcr-2016-12-en&mimeType=text%2fhtml&containerItemId=%2fcontent%2fserial%2f20747721&accessItemIds=&option6=imprint&value6=http%3a%2f%2foecd.metastore.ingenta.com%2fcontent%2fimprint%2foecd>.

ёстой юм.” Бусад томоохон байгууллагууд болох Азийн Хөгжлийн Банк, мөн НҮБ-ын Ази ба Номхон Далайн Эдийн Засаг ба Нийгмийн Байгууллага дээрхтэй төстэй тодорхойлолтуудыг ашигладаг бөгөөд ингэхдээ хамаарагч талуудын хамтын үйл ажиллагааг онцолсон байна.⁴

Компаниуд КНХ-тэй уялдаатай үйл

ажиллагаа ба стратегиудаа ярихдаа мөн олон янзын нэр томъёолуудыг ашигладаг бөгөөд энэ нь ойлголтын хоорондын зөрүүнүүдийг харуулсаар байна. Жишээлбэл, 2013 оны KPMG судалгаанд хамрагдсан 100 компанийн дийлэнх нь КНХ-ын тайлагналаа 8 ялгаатай нэр томъёолоор илэрхийлсэн байна:⁵



Зураг 1: Зохиогчийн 2013 KPMG судалгаанд суурилсан дүрслэл

Энд ашиглагдсан нэр томъёонуудын зарим нь нэлээд ойлгомжгүй байгаад зогсохгүй жижиг компаниудын хувьд КНХ-ыг хийх шаардлагагүй мэт сэтгэгдэл төрүүлэхээр байгаа. Үүний үр дүнд ч тэд КНХ/хариуцлагатай/тогтвортой бизнесийн төслүүдэд оролцохдоо хойрго ханддаг байж мэдэх юм. Гэхдээ урт хугацаандаа компаниуд бизнесийн салбарт тогтвортой байдлыг өөрсдийн хэмжээ, бүтэц ба хуулийн хэлбэрээс үл хамааран өгөгдсөн боломжуудыг олж харан оролцох чадвартай байж л олж авна. Тиймээс хариуцлагатай бизнесийн зарчмуудын өдөр тутмын нөлөөллүүд ба үр өгөөжийг компаниудын ажиллаж буй орчин нөхцөлийнх

нь хувьд тайлбарлах нь маш чухал байсаар байна.

1.2. АМЖИЛТТАЙ КНХ-ЫН ҮР АШИГ БА СУУРЬ НӨХЦӨЛҮҮДИЙГ ТАЙЛБАРЛАХ НЬ

Энэ хэсэгт компанийн талаас бий болох КНХ-ын үнэ цэнүүдийн тухай олон улсын зөвлөх компанийн хийсэн саяхны судалгааг товч толилуулж байна. Үүний зорилго нь КНХ нь урт хугацаандаа компанид санхүүгийн болон санхүүгийн бус үр өгөөжтэй байдаг бөгөөд КНХ-ын тоглогч байснаар ямар эерэг боломжууд байж болохыг тодорхойлон харуулахад оршино.

⁴ See e.g. www.unescap.org/sites/default/files/3Cs_handbook.pdf.

⁵ Source: KPMG International, The KPMG Survey of Corporate Social Responsibility Reporting 2013, December 2013.

Байгаль орчин, нийгмийн ба засгийн газрын хөтөлбөрүүдийн компанийн санхүүгийн гүйцэтгэлд үзүүлэх нөлөө

Сүүлийн хэдэн жилд хийгдсэн судалгаануудаас харахад хариуцлагатай бизнес нь компанид өрсөлдөөний давуу тал бий болгодог болохыг баталсаар байгаа бөгөөд эдгээр нь ашигт ажиллагаа нэмэгдэх, капиталын өртөг буурах болон ажилтнуудын ажлын байрны тогтвортой байдал өсөх зэргээр ажиглагддаг байна. Тухайлбал 2015 онд хийсэн шинжлэх ухааны судалгаагаар КНХ-тай байснаар компанийн өрийн өртөг 40% ба түүнээс дээш хувиар буурч, орлого 20% хүртэл өсөх боломжтой гэжээ.⁶ Үүнтэй адилаар АНУ-ын компаниудын гүйцэтгэлийг 18 жил судалсан салбар хоорондын судалгаа “тогтвор сайтай” компаниуд буюу байгаль орчин, нийгэм ба төр засгийн системд

хандсан үйл ажиллагаануудыг хэрэгжүүлдэг компаниуд “тогтвор муутай” компаниудтай харьцуулахад хувьцааны гүйцэтгэл болон бодит бүртгэлийн тоон утгуудаар давуу гүйцэтгэлтэй байсныг баталсан байна.⁷ Судалгаанаас үзэхэд гүйцэтгэл сайжирсан шалтгаан нь чадварлаг хүний нөөцийг татах, илүү найдвартай бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээ байгуулах, уялдаатай хамаарагч талуудтай үүсэж болох өртөг зардал өндөр зөрчил сөргөлдөөнөөс зайлсхийн өрсөлдөөнт чадвараа хадгалахын тулд бүтгээгдхүүн ба үйл явцдаа илүү анхаарал хандуулах зэрэгтэй холбоотой байсан байна.

Илүү өргөн цар хүрээнд 2009 онд McKinsey-гийн бэлдэж гаргасан “КНХ-ыг үнэлэх нь” гэдэг олон улсын түвшний судалгаа тайланг авч үзэж болно.⁸ Судалгаагаар КНХ-ыг хэрэгжүүлснээр компани санхүүгийн гүйцэтгэлдээ эерэг үр нөлөө бий болгодог нь



⁶ Rochlin, Bliss, Jordan, Kiser, Defining the Competitive and Financial Advantages of Corporate Responsibility and Sustainability, IO Sustainability and Babson, 2015, <http://projectroi.com/wp-content/uploads/2015/07/Project-ROI-Report.pdf>.

⁷ Eccles, Joannou, Serafeim, The Impact of Corporate Sustainability on Organizational Processes and Performance, National Bureau of Economic Research, Working Paper 17950, <http://www.nber.org/papers/w17950>.

⁸ McKinsey, Valuing corporate social responsibility, Survey 2009, see <http://www.mckinsey.com/business-functions/strategy-and-corporate-finance/our-insights/valuing-corporate-social-responsibility-mckinsey-global-survey-results>.

сайн нэр хүндтэй байх, чадварлаг ажилтнуудыг татах, үр өгөөжийг сайжруулан өртөгийг бууруулах, өсөлтийн шинэ боломжуудыг бий болгох болон хөрөнгө оруулалтыг хялбараар босгох зэрэг шалтгаануудаар илэрч байжээ. Компанийн төлөөлөгчид, хөрөнгө оруулалт ба КНХ-ын мэрэгжилтнүүдийн тодорхойлсноор нэр хүнд ба чадварлаг хүний нөөцийн бүрдэлт нь компанийн хувьд хамгийн чухал нөлөө үзүүлдэг хүчин зүйлс болохыг судалгаанд тусгасан байна. Хэдийгээр судалгаанд өгүүлснээр хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнэд эерэг нөлөө үзүүлснийг санхүүгийн гүйцэтгэлээр илэрхийлэх нь нэлээд түвэгтэй боловч судалгаагаар байгаль орчин ба нийгмийн хөтөлбөрүүд нь урт хугацаандаа, харин засгийн газрын хөтөлбөрүүд богино хугацаанд эзэмшигчдийн хөрөнгөнд эерэг нөлөө үзүүлдэг болохыг баталсан байгаа юм.

McKinsey-гийн 2009 судалгааны үр дүнг 2015 онд Deloitte-ийн хэвлүүлсэн КНХ-ын Менежер судалгаа давхар баталсан байна. Судалгаа КНХ-ын менежерүүдийн өнцгөөс Төв Европын орнуудад КНХ-ын үзүүлэх нөлөөлөлүүдийг авч үзсэн бөгөөд үр дүнгээс харахад КНХ нь дотооддоо ажилтнуудын идэвх оролцоог нэмэгдүүлж (үр дүнд нь боловсон хүчний эргэлт буурна) тэдний ёс зүйн хэм хэмжээг өргөсөн бол гадаад орчиндоо компанийн бүтээгдхүүнүүдийн нэр хүндийг өсгөн нийгмийн хариуцлагатай гэсэн тодорхойлолттой болоход нөлөөлсөн байжээ. Мөн нийгмийн бүлгүүдтэй харьцах харьцаа сайжрах болон хэрэглэгчдийн итгэл өсөх зэрэг эерэг нөлөөллүүдийг бас энд дурдсан

байна.⁹

Мөн Deloitte-ийн илрүүлснээр КНХ-ын хамгийн үр дүнтэй арга хэрэгслүүд нь компанийн сайн дурын ажлууд, ажилтнуудад зориулсан ёс зүйн хөтөлбөрүүд болон хамаарагч талуудтай үүсгэх олон талт харилцаа зэрэг байсан байна.

Дээрхүүдээс гадна торгууль шийтгэлүүд нь компанийн хариуцлагад хэрхэн нөлөөлж байгааг судалсан судалгаанууд бас олон хийгдсэн нь КНХ-ын буруу үйлдлүүд нь компаниудад улам ихээр өртөгтэй болсоор байгааг харуулж байна.¹⁰ Жишээлбэл Vigeo rating –ийн 2015 онд хийсэн олон улсын судалгаагаар 2012–2013 оны хооронд авч үзсэн 2500 компанийн 20% нь нийгмийн эсвэл байгаль орчны гүйцэтгэлдээ төрөл бүрийн хуулийн шийтгэлүүд хүлээснээр (бизнесийн зан төлөв, нийгмийн бүлгүүдтэй холбоотой харьцаа, ажилтнуудад хандах хандлага зэрэг чиглэлүүд) нийтдээ

95.5 тэрбум еврогийн төлбөр торгууль хүлээсэн байгаа юм.¹¹

Үүнтэй мөн адилаар, 2010 онд United Nations Global Compact Accenture-ийн хамт тогтвортой байдал болон хариуцлагатай бизнес/КНХ-ын тухай гүйцэтгэх захирлуудын ойлголтыг олон улсын хэмжээнд судалж нийтэлжээ.¹² Үр дүнгээс харахад нийт захирлуудын 96% нь тогтвортой байдлын асуудлуудыг компанийн стратеги ба үйл ажиллагаанд бүрэн уялдуулж нэгтгэх нь зөв гэж үзсэн байна. (2007 онд энэ нь 72% байсан). Захирлуудын 93% нь тогтвортой байдлын асуудлууд нь бизнесийн ирээдүйн

⁹ Deloitte, CSR Managers Survey 2015 in Central Europe. How CSR has influenced Central European societies and economies. Lessons learnt and future trends. https://www2.deloitte.com/content/dam/Deloitte/lt/Documents/strategy/LT_CSR_Managers_Report.pdf.

¹⁰ For a brief overview, see <http://mneguidelines.oecd.org/global-forum/2016-GFRBC-Session-Note-Business-performance.pdf>.

¹¹ Paying the penalty: The cost of CSR misconduct, vigeo rating, May 2015, http://www.vigeo.com/csr-rating-agency/images/stories/formulaires/2015_05_Related_Sanctions_version_finale_ENG.pdf. Most sanctions occurred to companies in the US and Europe which is explained by the stronger legal framework and the bigger responsibilities companies have to deal with in those regions.

¹² United Nations Global Compact, A New Era of Sustainability, UN Global Compact–Accenture CEO Study 2010, https://www.unglobalcompact.org/docs/news_events/8.1/UNGC_Accenture_CEO_Study_2010.pdf.

амжилтанд маш чухал гэж үзсэн байна. Мөн 72% нь “брэнд, итгэлцэл ба нэр хүнд” нь тогтвортой байдлын асуудлуудыг анхаарахад нөлөөлсөн хамгийн чухал 3 хүчин зүйлийн нэгд орно гэж үзжээ. Орлогын өсөлт ба зардлын бууралт нь 44%-аар 2-т бичигдсэн байна. Захирлуудын 72% нь дэлхийн хөгжлийн тухай мэдлэг боловсрол нь тэдний бизнесийн ирээдүйн амжилтанд хамгийн чухал нөлөөтэй гэж үзсэн. 58% нь хэрэглэгчид нь нийгмийн уялдаатай асуудлуудыг удирдахад хамгийн нөлөө бүхий хамаарагч тал бөгөөд ажилтнууд 45%-аар дараагийн нөлөө бүхий хамаарагч тал мөн гэж үзсэн байна. 88% нь тогтвортой байдлыг бэлтгэн нийлүүлэлтийн хэлхээндээ уялдуулан тусгах хэрэгтэй гэж үзсэн бол 54% нь компанидаа үүнийг хэрэгжүүлж чадсан гэж үзжээ. Ирээдүйн бэрхшээлүүдийн тухай асуухад захирлуудын 49% нь тогтвортой байдлын стратегиудыг компанийн хэмжээнд хэрэгжүүлэх нь хамгийн амаргүй байх болно гэсэн бол компани доторх хүлээн зөвшөөрөх байдал, гадаад хамаарагч талуудтай харилцах харилцааны бэрхшээлүүд, уялдах ур чадвар ба мэдлэг дутуу болон ТУЗ-ын дэмжлэг сул ба ажилчдын сөрөг байдал зэргийг мөн дараагийн асуудлуудаар тодорхойлсон байгаа юм.

Хөгжиж буй орнууд ба шинээр гарч ирж буй зах зээлүүд дэх КНХ

КНХ-ын үйл ажиллагаанууд нь хөгжиж буй орнууд болон шинээр гарч ирж буй зах зээлүүдийн хувьд ялгаатай байгаа юм. Жишээлбэл Federation of the Indian Chambers of Commerce and Industry¹³-ийн 2016 оны судалгаагаар КНХ-ын оролцоо дараах талбаруудад илүү чухал хэрэгцээтэй

байна. Үүнд:

- ✓ Боловсрол ба сургалтыг дэмжих
- ✓ Өлсгөлөн ба ядууралтай тэмцэх ба эрүүл мэндийн үйлчилгээ ба эрүүл цэвэр орчинд амьдрах боломжийг дэмжих
- ✓ Байгаль орчныг хамгаалах
- ✓ Хөдөө орон нутгийн хөгжил ба
- ✓ Тэгш бус байдлыг бууруулах.

Боловсрол ба сургалтыг дэмжих, байгаль орчныг хамгаалах болон эрүүл мэндийн үйлчилгээгээр хангах зэрэг үйл ажиллагаануудыг компаниуд илүү анхаарч дэмжиж ажиллах ёстой тэргүүлэх 3 чиглэл гэж хөгжиж буй орнуудын иргэд, олон нийтийн зүгээс үзэж байгаа нь 2016 оны Edelman Trust Barometer-ээс харагдаж байгаа.¹⁴

Хэрэглэгчид ба иргэд олон нийт чиглүүлэгч хүч болох нь

Хөгжингүй орнууд, хөгжиж буй орнууд, эсвэл шинэ зах зээлүүд дээр үйл ажиллагаа явуулж байгаагаас үл хамааран хэрэглэгчид ба иргэд олон нийт нь бизнесийг хариуцлагатай, ёс зүйтэй хийхэд гол чиглүүлэгч хүч болж байгааг компанийн удирдлага, төлөөлөгчид илүү ихээр анзаарах болсон байна. Дээр дурдсан 2015 оны Deloitte-ийн судалгаагаар Төв Европын 10 оны КНХ-ын менежерүүд ирэх жилүүдэд бизнесийн загварууд өөрчлөгдөнө гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлсэн бөгөөд гол нөлөөлөл нь хэрэглэгчид нийгмийн хариуцлагатай бүтээгдхүүн үйлчилгээг илүү ихээр хүсэн шаардах болсонтой холбоотой гэсэн байна.¹⁵ Дэлхий хэмжээнд ч иймэрхүү үр дүн 2015 оны Cone Communications-ийн судалгаагаар батлагдаад байна. Тэдний Глобал КНХ-ын судалгаагаар харагдсан үр дүнгүүд гэвэл:

🕒 Дэлхий нийтийн хэрэглэгчдийн үзэж байгаагаар компаниуд нь нийгмийн болон байгаль орчны асуудлуудыг шийдэхэд

¹³ Federation of Indian Chambers of Commerce and Industry, Corporate Social Responsibility Survey, March 2016.

¹⁴ 2016 Edelman Trust Barometer, <http://www.edelman.com/insights/intellectual-property/2016-edelman-trust-barometer/>.

¹⁵ Deloitte, CSR Managers Survey 2015 in Central Europe. How CSR has influenced Central European societies and economies. Lessons learnt and future trends. https://www2.deloitte.com/content/dam/Deloitte/lt/Documents/strategy/LT_CSR_Managers_Report.pdf.

оролцож, илүү хариуцлагатай үйл ажиллагаа явуулах ёстой бөгөөд зөвхөн ашгийг хөөцөлдөх нь хангалттай бус юм.

📌 Нийт дэлхийн хэрэглэгчдийн 84% нь илэрхийлснээр бололцоотой үедээ нийгмийн ба байгаль орчны хариуцлага бүхий бүтээгдхүүн үйлчилгээнүүдийг авахыг эрмэлздэг бөгөөд 90% нь компаниудаас илүү хариуцлагатай бүтээгдхүүн, үйлчилгээ санал болгохыг хүсдэг гэжээ.

📌 Өнөө үед компанийн КНХ нь үйл ажиллагааны явцад байнга тохиолддог асуудлууд болоод байгаа учраас компани хүний нөөцийн шийдвэр гаргалт, үйл ажиллагааны лиценз авах болон санхүү, ашгийн тооцоо хийхдээ КНХ-ын ач холбогдлыг харгалзан үздэг байх нь чухал юм.

📌 Дэлхий нийтийн хэрэглэгчид өөрсдийн зах зээл дээр нь ямар компани үйл ажиллагаа явуулахыг хүсэж байгаа (84%), ямар компанид ажиллах (79%) хаана хөрөнгө оруулалт хийх тухай шийдвэр гаргахдаа (67%) компаниудын КНХ-ыг харгалздаг болжээ.

📌 Хэрэглэгчдийн 48% нь компаниуд хариуцлагатай байхыг хичээдэг гэсэн сохор итгэл үнэмшилтэй байдаг бол 52% нь өөрөөр батлагдаагүй л бол компаниуд хариуцлагагүй ажилладаг гэж үзсэн байна.

📌 Олон улсын хэрэглэгчдийн 64% нь хэлэхдээ хэрэв тодорхой компани бусдаасаа илүү, давуу ажилладаг бол тэр компанийн КНХ-ын үйл ажиллагаанд л анхаарал хандуулдаг гэжээ.

Ижил төстэй үр дүнгүүдийг Nielsen-ээс 2014 оны 6-р сард гаргасан Дэлхийн КНХ-ын Тайлангаас харж болохоор байна.¹⁶ Тайлангаас харахад хэрэглэгчид нийгмийн хариуцлагатай компанид ажиллахыг хүсдэг

(67%), нийгмийн болон байгаль орчны хувьд хариуцлага бүхий бүтээгдхүүнд илүү үнэ төлөхөд бэлэн (55%), мөн бүтээгдхүүний савлалт зэргийг компанийн хариуцлагын өнцгөөс нь шалгадаг (52%) гэсэн байгаа юм. Нийт асуулга өгөгчдийн 49% нь нийгмийн болон байгаль орчны хөтөлбөрүүд хэрэгжүүлж буй байгууллагад сайн дураараа ажиллах, хандив тусламж өгөхөд дуртай байх болно гэж хариулсан байна. Хэрэглэгчид бизнесээс илүү их хариуцлага шаарддаг болж буй хандлагыг 2016 оны Edelman Trust Barometer-ээс харж болно.¹⁷

Энд тусгаснаар нийт хүн амын 80% нь “компани ашгаа нэмэгдүүлэхийн зэрэгцээ өөрийн ажиллаж буй орчныхоо нийгэм эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулах тодорхой алхам, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж чадна” гэж үзсэн байна” (2015 онд 74% байсан).

Хамаарагч талуудын харилцаа чухал байр суурьтай болж байна

Ерөнхийдөө тайлагналын тухайд авч үзвэл ажилчдын ажиллах сонирхлыг татах нөхцөлүүд, компанийн ба брэндийн нэр хүнд зэрэг санхүүгийн бус компанийн мэдээллүүд илүү чухал болж байгаа бөгөөд үүнийг нэгдсэн тайлагнал дахь компанийн тогтвортой байдлын гүйцэтгэлийг харуулах хэсэг дээр юуг түлхүү тусгах тухай одоогийн хэлэлцүүлгүүдээс тод харж болно.¹⁸ Энэ нь дээр өгүүлсэн Cone 2015 судалгаагаар мөн харагдаж буй бөгөөд хэрэглэгчдийн хүлээлт нь зөвхөн КНХ-ын үйл ажиллагаануудтай уялддаг бус бас КНХ-ын тайлагналтай уялдаж тодорхойлогддог болохыг асуулга баталсан. Асуулгад хариулагчдын дийлэнх олонхи нь:

¹⁶ Nielsen, Global Corporate Social Responsibility Report, June 2014, <http://www.nielsen.com/content/dam/niensglobal/apac/docs/reports/2014/Nielsen-Global-Corporate-Social-Responsibility-Report-June-2014.pdf>.

¹⁷ 2016 Edelman Trust Barometer, <http://www.edelman.com/insights/intellectual-property/2016-edelman-trust-barometer/>.

¹⁸ See e.g. <http://www.pwc.com/gx/en/industries/retail-consumer/issue-integrating-financial--non-financial-reporting.html>, http://ec.europa.eu/finance/company-reporting/non-financial_reporting/index_en.htm, <https://www.unglobalcompact.org/>, <http://www.oecd.org/corporate/mne/>, <http://www.iso.org/iso/home/standards/iso26000.htm>.



✓ Компаниуд КНХ–ын үйл ажиллагаанууд нь хувь хүний түвшинд хэрхэн бууж уялдаж байгааг харуулах ёстой

✓ Компаниуд КНХ–ын үйл ажиллагаануудаа тайлагнах ёстой

✓ Компаниуд КНХ–ынхаа тухайд төгс төгөлдөр байх албагүй ч шударга ил тод байх ёстой

✓ КНХ–ын үйл ажиллагаануудыг тооцож хэмжиж болохуйц байх ёстой гэж үзсэн байна.

Компанийн зүгээс КНХ–д гарч буй саад бэрхшээлүүд

Хэдийгээр КНХ ба/эсвэл тогтвортой байдлын ирээдүйг өөдрөгөөр харж болох ч КНХ–ыг хэрэгжүүлэх, сайжруулахад хувь компанийн түвшинд ч, улс орон бүс нутгийн түвшинд ч саад бэрхшээлүүд цөөнгүй байгаа юм.

Дээр дурдсан Deloitte 2015¹⁹ судалгаанаас харахад

🕒 КНХ–ыг ямар нэг тусламж хандив, спонсорын үйл ажиллагаа гэж буруугаар ойлгох нь зөвхөн компани дотор ч бус бас КНХ–ын хамаарагч талуудад ч байсаар байна,

🕒 Зарим компаниуд КНХ–д хөрөнгө оруулалт хийхээс зайлсхийсээр байгаа нь бодит баримт юм,

🕒 КНХ “эргээд үр дүнгээ өгөхгүй” гэсэн ойлголт байгаа,

🕒 Удирдлагын мэдлэг мэдээлэл, нийт олон нийтийн ойлголт дутуу, мөн

🕒 Эдийн засгийн хүндрэлүүд зэрэг нь ирээдүйд КНХ–ыг хөгжүүлэхэд хамгийн ихээр саад болох нөхцөлүүд болсоор байна.

Эдгээрээс гадна 2010 United Nations Global Compact survey судалгаагаар ярилцлага өгсөн нийт гүйцэтгэх захирлуудын

¹⁹ Deloitte, CSR Managers Survey 2015 in Central Europe. How CSR has influenced Central European societies and economies. Lessons learnt and future trends. https://www2.deloitte.com/content/dam/Deloitte/lt/Documents/strategy/LT_CSR_Managers_Report.pdf.



49% нь тогтвортой байдлыг нийт компанийн хэмжээнд нэгдсэн байдлаар хэрэгжүүлэхэд бүтэц функцуудын дагуу тогтвортой байдлыг нэвтрүүлэн хэрэгжүүлэх нь маш түвэгтэй байгааг хамгийн том бэрхшээл гэж үзсэн байна. Судалгаанд өөр бусад стратегийн зорилтуудыг чухалчлах явдал 48%-аар 2-т дурдагдсан байна.²⁰

1.3. ДҮГНЭХ НЬ: ИТГЭЛЦЭЛ, ИЛ ТОД БАЙДАЛ, ЯРИА ХЭЛЭЛЦЭЭР БА ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦОЛЫН ҮҮРЭГ

Дээр өгүүлснээр дотоод гадаад хамаарагч талууд, тэр дотроо компани үйл ажиллагаагаа явуулж байгаа улс орны олон нийттэй харьцах харилцаа маш чухал үүрэгтэй болоод байна. Тэгэхдээ дэлхий нийтээр хийгдсэн 2016

Edelman Trust Barometer судалгаанаас харахад ерөнхий хүн амын итгэлцлийн ойлголт нь тухайн талбар дахь компаниудын гүйцэтгэл ба хэрэгжилтэнд гарч буй ойлголтоос нэлээд зөрүүтэй байгаа юм.²¹ Ёс зүйн зан төлөв, ил тод байдал ба хариуцлагатай үйлдэл, ажилчид ба хэрэглэгчидтэй харилцах харилцаа, бүтээгдхүүний чанар, байгаль орчин ба манлайллын чанар зэрэг бизнесийн практикууд дээр хүчтэй ялгаанууд байна. Мөн олон нийт компани өөрийн зүгээс байгаль орчныг хамгаалах, орон нутгийн нийгмийн бүлгүүдэд эерэгээр нөлөөлөх, нийгмийн хэрэгцээг өдөр тутмын бизнесдээ тусгах болон иргэний бүлгүүдтэй хамтран нийгмийн асуудлуудыг шийдэх эсэхэд хэр идэвх санаачлагатай ажиллах тал дээр эргэлзээтэй хандсаар байна.

²⁰ United Nations Global Compact, A New Era of Sustainability, UN Global Compact–Accenture CEO Study 2010, https://www.unglobalcompact.org/docs/news_events/8.1/UNGC_Accenture_CEO_Study_2010.pdf.

²¹ 2016 Edelman Trust Barometer, <http://www.edelman.com/insights/intellectual-property/2016-edelman-trust-barometer/>.

2. КНХ–ААС ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДАД ХҮРЭХ НЬ (ТХЗ)

2.1. ТХЗ–УУД НЬ ХАРИУЦЛАГАТАЙ БИЗНЕСИЙГ БИЙ БОЛГОХОД ЕРӨНХИЙ ХҮРЭЭ, ЧИГ ШУГАМ БОЛОХ НЬ

НҮБ тогтвортой хөгжлийг ирээдүй үеийнхэн өөрсдийн хэрэгцээгээ хангахад нь хүндрэл учруулахгүйгээр өнөөдрийн хэрэгцээгээ хангаж чадах тэр хөгжил гэж тодорхойлсон байдаг. НҮБ–ийн тодохойлсноор тогтвортой хөгжил нь үндсэн 3 суурь элементүүд дээр тогтох бөгөөд эдгээр нь: эдийн засгийн өсөлт, нийгмийн оролцоо ба байгаль орчны хамгаалал юм. Эдгээр элементүүд нь харилцан уялдаа холбоотой бөгөөд “бүгдэд

тэгш боломжуудыг хангаж, тэгш бус байдлыг бууруулан, амжиргааны суурь түвшинг нэмэгдүүлэн, эрх тэгш нийгмийн хөгжил ба оролцоог хөгжүүлж, байгалийн нөөц баялаг ба экосистемийг нэгдсэн, тогтвортой байдлаар удирдах явдлыг дэмжих замаар тогтвортой, оролцоотой, эрх тэгш эдийн засгийн өсөлтийг” хангахад шаардлагатай юм.²²

Тиймээс ч ажил хэргийг эхлүүлэхийн тулд 2015 оны 9–р сард НҮБ–ийн гишүүн орнууд ядуурлыг зогсоож, дэлхийгээ хамгаалан бүгдэд хөгжил дэвшлийг хангахын тулд 17 ТХЗ–уудыг санал нэгтгэйгээр хэрэгжүүлэхээр болсон юм.²³



Зураг 2: 17–н Тогтвортой Хөгжлийн Зорилтууд

²² See <http://www.un.org/sustainabledevelopment/development-agenda/#8e74e7178ec1f94c8>.

²³ See <http://www.un.org/sustainabledevelopment/sustainable-development-goals/>.

Зорилт бүр дараагийн 15 жилд хангах ёстой тодорхой үзүүлэлтүүдтэй бөгөөд (нийтдээ 169) орон бүрийн засгийн газар, хувийн сектор ба нийгмийн бүлгүүдийн үүрэг хариуцлага, санал санаачлагыг шаардаж байгаа юм. Эдгээр нь улс тус бүрийн өөрсдийн тогтвортой хөгжлийн бодлого, төлөвлөгөө ба хөтөлбөрүүдээс хамаарах бөгөөд улс орон бүр өөрсдөө удирдан манлайлах үүрэгтэй.

Бизнесүүдэд гарах үр өгөөж ба тэдний үүргийг НҮБ-ийн байр сууринаас авч үзсэн нь

НҮБ-ийн тодорхойлсноор бизнесийн лидерүүд ба хөрөнгө оруулагчид нь компаниудын хувьд “богино хугацааны ашиг орлогодоо төвлөрөх нь хангалттай биш бөгөөд учир нь байгалийн гамшиг, нийгмийн тэмцэл хөдөлгөөн, эсвэл эдийн засгийн тэнцвэргүй байдлууд нь урт хугацааны өсөлт хөгжилд сөргөөр нөлөөлдөг учраас ийм нөхцөлүүдийг ойлгож уялдах арга хэмжээ авч чадаж буй бизнесүүд ямагт алхам урд явах болно” гэдгийг илүү сайн ойлгох болсон байна. Энэ хүрээнд Дэлхийн Зорилтуудыг бүс нутгийн бизнес болгосон нөхцөлд ТХЗ-ууд нь компаниудад дэлхий даяар шинэ зах зээлүүд, шинэ боломжуудыг бий болгох хэрэгслүүд болж чадах юм.²⁴

Өмнөх үеийн зорилтууд болох Мянганы Хөгжлийн Зорилтуудаас ялгаатай нь ТХЗ-ууд нь компаниудаас шууд бус байдлаар өөрсдийн бүтээлч байдал, санал санаачлагаа ашиглан тогтвортой хөгжлийн бэрхшээлүүдийг шийдэхэд уриалан дуудаж байна. ТХЗ-ууд нь “дэлхийн тогтвортой хөгжлийн хамгийн том саад бэрхшээлүүдийг шийдэхэд бизнесүүд тэргүүлсэн шийдэл ба технологиудыг бий болгон ашиглах өргөн боломжийг олгож байгаа” гэж НҮБ үзэж байна. “ТХЗ-ууд нь

нийгмийг хөгжүүлэх дэлхий нийтийн зорилт чиглэлүүдийг тодорхойлсноор компаниудад тэдний бизнес хэрхэн тогтвортой хөгжлийг урагшлахад тусалж чадахаа харуулах боломжийг олгож байгаа бөгөөд үүнийг нэгэн зэрэг хүмүүс болон газар дэлхийд үзүүлэх сөрөг нөлөөллүүдээ бууруулан эерэг нөлөөллүүдээ ихэсгэх замаар шийдэх ёстой.”²⁵ НҮБ-ийн ТХЗ Compass²⁶ –бизнес тэргүүлсэн гарын авлагад тусгаснаар ТХЗ-ууд нь ядуурал, эрүүл мэнд, боловсрол, цаг агаарын өөрчлөлт ба байгаль орчны бохирдол зэрэг компаниудад хамаатай олон чиглэл бүхий сэдвүүдийг хамарч байгаа юм. Зорилтууд нь бизнесийн стратегиудыг дэлхий нийтийн тэргүүлэх

асуудлуудтай холбож өгч тэдний стратегиуд, зорилтууд болон үйл ажиллагаануудыг хэлбэржүүлж, чиглүүлж, харилцан холбож бас тайлагнах боломжоор хангах юм. Ийм байдлаар компаниуд ирээдүйн бизнесийн боломжуудаа тодорхойлох гэх мэт олон үр өгөөжийг өөртөө бий болгож чадна гэж НҮБ үзэж байна. Мөн ТХЗ-ууд нь компаниудын хувьд нөөц, эх үүсвэрүүдээ үр ашигтай ашиглах эдийн засгийн сонирхолыг нь нэмэгдүүлэх бөгөөд бас илүү тогтвортой сонголтууд руу шилжих сонирхлыг ч өдөөж өгч болох юм.

НҮБ-ын цаашид тодруулснаар бол ТХЗ-уудад хүрэхийн тулд хөрөнгө оруулах нь бизнесийн амжилтын суурь нөхцөлүүдийг дэмжих алхам болох бөгөөд учир нь дүрэм журам бүхий зах зээл, ил тод санхүүгийн системүүд болон авлига үгүй сайн засаглал бүхий институцийг дэмжих юм. Цаашлаад ТХЗ-ууд нь нэгдсэн үйл ажиллагааны цар хүрээ ба харилцааны арга хэлбэрүүдийг тодорхойлж өгсөнөөр өөрсдийн үзүүлэх нөлөө болон гүйцэтгэлийн тухайд хамаарагч

²⁴ See <https://www.unglobalcompact.org/what-is-gc/our-work/sustainable-development>.

²⁵ See <http://www.un.org/sustainabledevelopment/sustainable-development-goals/>.

²⁶ See <http://sdgcompass.org/>.

талуудтай илүү тогтвортой, бас үр дүнтэй харилцахад нь компаниудад туслах юм.

НҮБ-ын ТХЗ-уудын Compass Дэлхийн

Зорилтуудад хүрэхэд компаниуд хэрхэн оролцож болох 5 алхмыг тайлбарласан байна:

| | |
|---|--|
| 1 | Компаниуд ТХЗ-уудыг сайн мэдэж авах ёстой |
| 2 | Компаниуд үнэ цэнийн хэлхээнийхээ дагуу ТХЗ-уудад үзүүлэх эерэг болон сөрөг, одоогийн болон ирээдүйн нөлөөллүүдээ үнэлэн шинжилсний дагуу тэргүүлэх хүчин зүйлүүдээ тодорхойлох ёстой. |
| 3 | Бизнесийн талбарууд дахь нэгдмэл тэргүүлэх хүчин зүйлс болон сайн гүйцэтгэлүүдээ дэмжихийн тулд компаниуд зорилтууд тавих ёстой. Компанийн зорилтуудыг ТХЗ-уудтай уялдуулах нь тогтвортой хөгжилд компанийн удирдлагын үзүүлж буй дэмжлэг, хүчин зүтгэлийг тод томруун харуулахад тусална. |
| 4 | Компаниуд нь тогтвортой байдлыг суурь бизнес болон засаглалдаа нэгтгэн нийлүүлж тогтвортой хөгжлийн хэмжүүр зорилтуудыг бүхий л компанийн функцуудад суулгаж өгөх ёстой юм. Энэ шатанд компаниуд үнэ цэнийн хэлхээнийхээ дагуу, салбар хооронд, эсвэл засгийн газрын болон иргэний нийгмийн байгууллагуудтай түншлэлийг илүү түлхүү хэрэгжүүлж эхлэх ёстой. |
| 5 | Компаниуд нийтлэг хэмжүүрүүд болон нэгдмэл тэргүүлэх хүчин зүйлсүүдээ ашиглан өөрсдийн тогтвортой хөгжлийн гүйцэтгэлийг хамаарагч талуудад тайлагнан тэдэнтэй харилцаа холбоог үүсгэх ёстой. |

ТХЗ-уудын хэрэгжилт, мөн хамаарагч талууд, тэр дотроо компанийн зүгээс оруулах тодорхой хувь нэмрүүдийн тухай санаанууд нь дөнгөж хөгжлийнхөө шатанд явж буй учраас практик үр дүн, ирээдүйн хандлага чиглэл болон бэрхшээлүүдийн тухай мэдлэг туршлага бага байна. Дараагийн хэсгээс боломжит санаанууд болон ТХЗ-уудыг хангахад компаниудын оролцоог эерэг болон сөргөөр харуулах эхний туршлагуудыг үзэх боломжтой.

2.2. КОМПАНИУДЫН ХҮЛЭЭЛТ БА ҮҮРЭГ – ДЭЛХИЙ НИЙТИЙН (БИЗНЕСИЙН) ӨНЦГӨӨС АВЧ ҮЗЭХ НЬ

Мэдээж ТХЗ-уудын логик нь нийтлэг зорилтуудыг хамтран шийдэхэд оршиж байгаа

боловч туршлагаас харахад нийтлэг нэг зорилтыг шийдэхийн тулд хэд хэдэн хамаарагч талыг оролцуулан хийдэг олон улсын яриа хэлэлцээрүүд нь бие даасан группууд, тэр дотроо улс орны түвшний болон бизнесийн түвшний улс төрийн үүрэг хариуцлагуудыг бүрхэгдүүлэх, ойлгомжгүй болгох хандлага ажиглагдаж байна. Одоогоор энэ утгаараа ТХЗ-ууд нь хариултаасаа илүү олон асуултууд бий болгож байгаа ба хоорондын ойлголцол, тэр дундаа КНХ буюу хариуцлагатай бизнес гэдэг нь тэргүүлэгч орнуудад “сонгодог” утгаараа ойлгогдохоор хэмжээнд хөгжиж чадаагүй байгаа орнуудыг оролцуулсан яриа хэлэлцээр чухал шаардлагатай байна.

Ерөнхийдөө компаниуд ТХЗ-уудын хувьд 2 асуултанд хариулах хэрэгтэй байгаа юм:

- ✓ Ямар ТХЗ-ууд нь (нэг эсвэл нэгжээд)

тэдний бизнестэй уялдаатай гэж үзэж байна вэ, яагаад?

✓ ТХЗ–уудыг хэрхэн өөрсдийн тогтвортой байдлын стратегиудад нэгтгэн суулгах вэ?

Гүйцэтгэл одоогоор хязгаарлагдмал байгаа нь

Хэдийгээр бүхэлдээ НҮБ ТХЗ–уудад бизнесүүдийг нэгтгэн уялдуулах боломжуудыг өөдрөгөөр харж байгаа ч НҮБ–ийн ТХЗ–уудын тайлангуудаас харахад “бизнесүүдэд тавигдах шаардлага, хүлээлт ядаж хамгийн багадаа ямар байх тал дээр ойлголтууд тодорхойгүй хэвээр байгаа ба ялгаатай зорилтууд руу чиглэсэн бизнесийн манлайллын нэгдсэн тодорхойлолт үгүйлэгдсээр байна”. “Мөн ТХЗ–уудын практик одоогийн байгаа тогтвортой байдлын зарчмууд, стандартууд болон хүлээсэн үүрэг зорилтуудтай хэрхэн уялдаж байгаа нь олон компаниудад тодорхойгүй хэвээр байгаа юм.”²⁷

Иймээс хэдийгээр НҮБ болон бусад институцууд компаниудыг чиглэл зөвлөмжүүдээр хангаж туслахыг оролдож байгаа ч ТХЗ–уудад хүрэх гэсэн компаниудын өөрсдийн үйл ажиллагаа, хүсэл эрмэлзэл тааруухан байгаа гэж үнэлж болно: Дэлхийн хэмжээнд 2017 онд тогтвортой байдлын мэргэжилтнүүдийн дунд ТХЗ–уудад компанийн үзүүлж буй хариу үйлдэл болон боломжуудыг олж харж байгаа байдалтай холбоотой хийгдсэн судалгаагаар ТББ–ууд, нийгмийн байгууллагууд болон НҮБ ТХЗ–уудыг урагшлуулахад бүхий л чармайлтаа гаргаж байгаа гэж үнэлэгдсэн бол хувийн сектор болон улс орны засгийн газруудын оролдлого чамлалттай үнэлэгдсэн.²⁸

Үүнээс гадна энэхүү GlobeScan судалгаанд хамрагдагчид ТХЗ–уудын дэлхий нийтийн ахиц дэвшилд шүүмжлэлтэй хандсан байгаа: нийт оролцогчдыг бүхэлд нь хамруулан ахиц дэвшлийг үнэлэхэд зөвхөн 9% нь сайн ахиц гарч байгаа гэсэн бол 54% нь сөрөг, 36% нь саармаг буюу бараг ахиц гараагүй гэсэн хариултауд өгсөн байна.²⁹ Задлаад үзвэл Азийн асуулганд зөвхөн 43%, нийт дэлхийн компаниудын төлөөлөлд тавьсан асуулганд 45% нь сөрөг хариулт өгсөн бол гол сөрөг хариултауд Европын болон Хойд Америкийн асуулгуудаас харагдаж байна (тус бүрдээ 57%). Ерөнхийдөө засгийн газрууд дэлхийн хэмжээнд ахиц гарсан гэж үзсэн бол (44% нь л сөрөг хариулт өгсөн) академикууд болон судлаачид хамгийн ихээр шүүмжтэй хандсан байна (58% нь сөрөг).³⁰

Гэхдээ дээрхийн зэрэгцээ GlobeScan–д хамрагдсан компанийн төлөөлөгчдийн зөвхөн аравны нэгээс бага хувь нь тэдний компани одоогоор ТХЗ–уудад хувь нэмэр оруулаагүй эсвэл оруулахаар төлөвлөөгүй гэсэн хариулт өгсөн байсан нь хүчтэй манлайлал ба хамаарагчдад зориулсан чиглэл зөвлөмжүүд хэвээр байна гэж үзвэл гүйцэтгэл цаашид сайжирна гэсэн найдвар төрүүлж байна.

Ирээдүйн бэрхшээлүүд – Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох болон хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэлийн зорилтууд дээр ахиц маш удаан байгааг экспертүүд онцолж байна

Нийт 17–н ТХЗ–ууд дээр өгөгдсөн Global society–ийн гүйцэтгэлийн үнэлгээ нэлээд ялгаатай үр дүнгүүд харуулаад байна:³¹

²⁷ See <https://www.unglobalcompact.org/take-action/action/sdg-blueprint>.

²⁸ GlobeScan, Evaluating Progress Towards the Sustainable Development Goals, March 2017, <http://www.globescan.com/component/edocman/?view=document&id=271&Itemid=591>, pp. 3, 12.

²⁹ GlobeScan, Evaluating Progress Towards the Sustainable Development Goals, March 2017, <http://www.globescan.com/component/edocman/?view=document&id=271&Itemid=591>, p 8.

³⁰ GlobeScan, Evaluating Progress Towards the Sustainable Development Goals, March 2017, <http://www.globescan.com/component/edocman/?view=document&id=271&Itemid=591>, p 9.

³¹ GlobeScan, Evaluating Progress Towards the Sustainable Development Goals, March 2017, <http://www.globescan.com/component/edocman/?view=document&id=271&Itemid=591>, p 10.

🕒 Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх (зорилт 9), сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх (зорилт 7), хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх (зорилт 17), уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах (зорилт 13), ба жендерийн эрх тэгш байдлыг хангах (зорилт 5) зорилтууд хамгийн ахицтай дэвшиж байгаа бол,

🕒 Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл (зорилт 12), эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох (зорилт 8), ба тэгш бус байдлыг бууруулах (зорилт 10) зорилтууд хамгийн ахиц багатай байгаа юм.

Тогтвортой хөгжлийн дэвшилд хамгийн их нөлөө үзүүлж буй зорилтуудын тухай асуухад оролцогчид Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах, Чанартай боловсролыг дэмжих, Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл, Энх тайван шударга ёсыг цогцлоох, мөн Тэгш бус байдлыг бууруулах зэрэг зорилтуудыг эхний 5-д жагсаасан бол Инноваци, дэд бүтцийг хөгжүүлэх, Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх зэрэг зорилтуудыг ач холбогдол багатай, харин Эдийн засгийн өсөлт ба баталгаат ажлын байрыг бий болгох зорилтыг дундаж нөлөөлөлтэй гэж үзсэн байна. Ази, Европ ба Хойд Америкийн хамаарагч бүлгүүд бүгд Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах зорилтыг хамгийн чухал зорилт гэж үзсэн бөгөөд Чанартай боловсролыг дэмжих, Тэгш бус байдлыг бууруулах болон Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэлийн зорилтууд удаалсан байна. Энд гэхдээ газарзүйн ялгаанууд байгаа нь Чанартай боловсролыг дэмжих (Африк/Ойрх дорно) ба Тэгш бус байдлыг бууруулах (Латин Америк) зорилтуудыг хамгийн чухал зорилтууд болоход бас нөлөөлсөн байна. Хамгийн их анхаарал татаж байгаа болон хамаарагчдын зүгээс хамгийн их зүтгэл шаардаж байгаа зорилтуудыг асуухад GlobeScan судалгаанд

оролцогчид нийтдээ Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах зорилтыг тодорхойлсон бол Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих зорилт Азийн оролцогчдын хувьд хамгийн анхаарал хандуулах зорилт гэсэн байна.

ТХЗ-уудад үүрэг хүлээх нь компаниудад дэлхий нийтээр бизнест итгэх итгэл буурч байгаагийн эсрэг алхам хийх боломж болох нь

GlobeScan судалгаагаар ТХЗ-ууд нь компаниудад зорилтуудыг хангахад заавал оролцох дарамт бус харин хөгжлийн зорилтуудтай уялдаатайгаар боломж бололцоонуудыг бий болгож байгаа нь харагдаж байна.³²

Судалгаанд оролцогчдын дийлэнхийн хэлснээр тэдний компани ТХЗ-уудад дараах байдлаар уялдаж байгаа бөгөөд үүнд:

✓ ТХЗ-уудад зохицох, уялдах шийдэл болох бүтээгдхүүн үйлчилгээнүүдийг хөгжүүлэх

✓ Өөрсдийн суурь бизнесийн үйл ажиллагаа, эсвэл санал санаачлагуудыг нийгмийн хэрэгцээнд тохируулах, уялдуулах

✓ ТХЗ-уудтай уялдаатай түншлэлийг байгуулах, эсвэл стратеги ба зорилгуудаа тодорхойлохдоо Дэлхийн Зорилтуудыг боломж гэж харах.

✓ Тогтвортой байдлын стратегиуд ба зорилтуудыг тодорхойлохдоо ТХЗ-уудыг боломж гэж харах

✓ Компанийн нийгэм ба байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг хязгаарлах зорилтуудыг гаргах, мөн

✓ Дэмжиж байгаа бодлогууд ба тохиромжтой хууль эрх зүйн орчинг хөхүүлэх, дэмжих, хамгаалах г.м.

Яагаад компаниуд ТХЗ-ууд хувь нэмэр оруулж, эсвэл оруулахаар төлөвлөж байгааг асуухад 2017 GlobeScan судалгаанд оролцогчдын дийлэнх нь суурь бизнесийн үйл ажиллагаануудаа, эсвэл шинэ санаачлагуудаа

нийт нийгмийн хэрэгцээтэй нийлүүлэн уялдуулах боломжуудыг олж харж байгаа, мөн тогтвортой байдлын стратегиуд, орлогоо нэмэгдүүлэх, шинэ зах зээлд өргөжих, бас боломжит нэр хүндийн өсөлтөөс ашиг бий болох боломжууд байгааг харж байгаагаа илэрхийлсэн байна.³³ Олон оролцогчид дэлхий нийтийн хэмжээнд ТХЗ–уудын ач холбогдлыг онцолсон байгаа юм. Сонирхолтой нь GlobeScan судалгаанд оролцогчдын 4% нь л сайн дурын сайн санааны хувь нэмрийг дурдсан байгаа нь компаниуд ТХЗ–уудад шууд хувь нэмрээ оруулах арга зам хайж байгаагийн илрэл болов уу гэж судалгаанд дүгнэхэд хүргэсэн байна.³⁴

Иймээс ТХЗ–уудад хариуцлага хүлээснээр итгэлцэл болон манлайллыг эргүүлэн олох боломж гэж үзэж байгаа нь судалгаагаар харагдаж байгаа юм. Мөн энэ нь олон улсын түвшний Edelman Trust Barometer 2017 судалгааны үр дүнд өгөх урт хугацааны хариулт болох юм:³⁵ Дэлхий нийтээр бизнес, засгийн газар, ТББ–ууд болон хэвлэл мэдээлэлд итгэх итгэл нь буурсаар байгаа бөгөөд илүү олон хүмүүс эдгээр группууд хэдийгээр голлох үүрэгтэй боловч “зөв зүйлс” хийж байгаа гэдэгт эргэлзэх болсон байна. Цаашлаад “систем” ажиллахгүй байгаа нь шударга ёс, итгэл найдвар алдагдахад хүргэж өөрчлөлт хийх хүсэл сонирхолыг дэлхий нийтээр нэмэгдүүлж байна.³⁶

Мөн судалгаанаас харахад дэлхий нийтээрээ нийгмийн асуудлуудыг шийдэхэд бизнес тэргүүлэх үүрэг гүйцэтгэх ёстой гэсэн хүлээлт байгаа юм: Судалгаанд оролцогчдын

75% нь “Компани өөрийн ажиллаж байгаа орчиндоо эдийн засгийн болон нийгмийн эерэг өөрчлөлтүүдийг авчрах замаар ашиг орлогоо нэмэгдүүлэх тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж чадна” гэж үзсэн байна.³⁷

Тодруулбал хямралын үед компаниудаас:

- ✓ Өөрсдийн ажилчиддаа сайн хандах
- ✓ Өндөр чанартай бүтээгдхүүн/үйлчилгээ үзүүлэх
- ✓ Хэрэглэгчдээ сонсох
- ✓ Өөрсдийн татвараа шударгаар төлөх, бас
- ✓ Ёс зүйтэй бизнесийн үйл ажиллагаатай байх зэрэг хүлээлт байх юм.

Мөн компаниуд өөрсдийн тэргүүлэх асуудлууд болон хүлээлтүүдээ тодорхойлж байх үедээ зөвхөн өөрсдийн бизнесийн хэрэгцээнүүдээ хангахаар бус эдийн засаг, нийгмийн хэрэгцээнд уялдаа бүхий бүтээгдхүүн үйлчилгээнүүдийн хэрэгцээг хангах талаас нь шинжилж байх хэрэгтэй юм.³⁸ Үүний зэрэгцээ судалгаанд өгсөн хариултуудаас харахад бизнес дараах практикуудыг үргэлжлүүлснээр итгэлцэл, эцэстээ үйл ажиллагааныхаа лицензийг ч алдахад хүрэх болно:³⁹

- ⌚ Гэрээ хэлцлүүдэд ялахын тулд төрийн түшмэдийг хахуульдах
- ⌚ Захирлууддаа ажилчдаасаа зуу, зуу дахин илүү цалин төлөх
- ⌚ Татвараас зайлсхийхийн тулд ашгаа өөр улсууд руу гуйвуулах
- ⌚ Хүмүүст шаардлагатай бүтээгдхүүн үйлчилгээндээ хэт өндөр үнэ тогтоох
- ⌚ Бүтээгдхүүн үйлчилгээний чанарыг бууруулж зардлаа хэмнэх.

³² GlobeScan, Evaluating Progress Towards the Sustainable Development Goals, March 2017, <http://www.globescan.com/component/edocman/?view=document&id=271&Itemid=591>, p 21.

³³ GlobeScan, Evaluating Progress Towards the Sustainable Development Goals, March 2017, <http://www.globescan.com/component/edocman/?view=document&id=271&Itemid=591>, p 22.

³⁴ GlobeScan, Evaluating Progress Towards the Sustainable Development Goals, March 2017, <http://www.globescan.com/component/edocman/?view=document&id=271&Itemid=591>, p 21.

³⁵ Edelman Trust Barometer 2017, <http://www.edelman.com/global-results/>, p. 10.

³⁶ Edelman Trust Barometer 2017, <http://www.edelman.com/global-results/>, p. 20.

³⁷ Edelman Trust Barometer 2017, <http://www.edelman.com/global-results/>, p. 41f.

³⁸ Edelman Trust Barometer 2017, <http://www.edelman.com/global-results/>, p. 46.

³⁹ Edelman Trust Barometer 2017, <http://www.edelman.com/global-results/>, p. 44.

3. МОНГОЛЫН НӨХЦӨЛД ХИЙХ ДҮГНЭЛТ БА АВСАН СУРГАМЖ – ХАМААРАГЧ ТАЛУУДЫН ИДЭВХТЭЙ ОРОЛЦОО БА ХООРОНДЫН ЯРИА ОЙЛГОЛЦОЛ АМЖИЛТЫН ГОЛ ХҮЧИН ЗҮЙЛ БОЛОХ НЬ

Өмнөх хэсэгт өгүүлснээр хариуцлагатай бизнес гэдэг нь зөвхөн “сайн бизнес” хийхийн нэр бус бас **ажилтнуудтайгаа болон гадаад хамаарагч талуудтай харилцах**, мөн ил тод нээлттэй байдлаар, үүрэг хариуцлагатай байдлаар тайлагнах зэрэг хүчин зүйлүүдийг хэлэх юм. Иймээс КНХ/хариуцлагатай/ тогтвортой бизнес ба түүний компанид өгөх

үр өгөөжийг ойлгох, бас хариуцлагатай бизнес ба тогтвортой байдал дээр хүчтэй төвлөрсөн бизнесийн орчинд учрах саад бэрхшээлүүдийг ойлгох нь компанийн төлөв хандлага (дотоод хэмжээс) болон компанийн КНХ-ын практикуудыг хамаарагч талын зүгээс ойлгон хүлээн авах нөхцөлүүдийг давхар шаардах юм:

| Дотоод ойлголт мэдлэг | Гадаад ойлголт мэдлэг |
|--|---|
| <ul style="list-style-type: none"> ✓ КНХ-ын утга агуулгыг ойлгох ✓ Компанийн түвшинд КНХ-д хөрөнгө оруулахын шалтгаан, бас саад бэрхшээлүүдийг тодорхойлох | <ul style="list-style-type: none"> ✓ КНХ-д хамаарагч талуудын зүгээс өгч буй ач холбогдол |
| <ul style="list-style-type: none"> ✓ КНХ-ын бодлого ба арга практикуудыг боловсруулах, ажиллуулах | <ul style="list-style-type: none"> ✓ Хувь компанийн КНХ-ын практикийг үзэх үзэл |
| <ul style="list-style-type: none"> ✓ Дотоод харилцаа холбоо | <ul style="list-style-type: none"> ✓ Хамаарагч талын ойлголт, хүлээн авалт ✓ Хамаарагч талын хүлээлтүүд |

ТХЗ-уудад хувь компанийн оруулах хувь нэмрийг авч үзвэл боломж бололцоо ба бусдын хүлээлтийн талаарх **хамаарагч талуудын харилцаа холбоо ба яриа хэлцэл** маш чухал ач холбогдолтой болж байна. ТХЗ-уудын нарийн түвэгтэй байдал ба хоорондоо уялдаа бүхий хөгжлийн бэрхшээлүүдээс хамаарч илүү харилцаа холбоо зайлшгүй хэрэгтэй байгаагаас гадна мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар олон нийт ба хувийн бизнесүүдийн зүгээс **хоорондын итгэлцлийг бий болгон шинэ төрлийн ил тод манлайллыг эхлүүлэх нэн тэргүүний шаардлага** байгаа юм. ТХЗ-уудын хувьд

авч үзвэл дээрх судалгаануудаас харахад одоогоор засгийн газрууд, компаниуд, ТББ-ууд, судлаачид болон бусад хамаарагч талууд бүгд Дэлхийн Зорилтууд болон уялдаа бүхий асуудал бэрхшээлүүд дээр ялгаатай байр суурьтай байсаар байна. Хамаарагч талуудын хооронд, дотроо санал санаа, шийдлээ солилцох, ярилцах нь тогтвортой хөгжлийг амжилттай хэрэгжүүлэхийн хамгийн чухал, суурь элемент болоод байна. Дээр авч үзсэн нийт судалгаануудад ажилтан албан хаагчдыг боловсруулан мэдлэгжүүлж эрх мэдэл олгох нь бизнесийг тогтвортой компанийн бүтэц руу шилжихэд туслах гол түлхүүр хүчин зүйл гэж

олон удаа дурдагдсан байсан. Ажилтнууд нь гүйцэтгэлийг төлбөртэйгээр хийж гүйцэтгэх хамаарагч тал мөнөөс гадна өдөр тутмын бизнесийн шийдлүүдэд өөрсдийн санаа бодлыг оруулдаг бөгөөд компанийн зүтгэл чармайлтын тухай мэдээлэлийг тараагч болж нөлөө үзүүлдэг тал юм.

Эдгээр үр дүнгүүд нь компанийн зүгээс Монгол дахь нөхцөл байдлыг харуулсан дараагийн хэсгийн “нүүр–танилцуулга” болж өгнө: Дэлхийн түвшинд өгүүлсэнтэй адилаар Монголын хамаарагч талууд Монгол дахь хамгийн тэргүүлэгч асуудлуудыг ойроос хараад улс орныхоо ирээдүйг хамтран өөрчлөхөд хаанаас, нийтээрээ эхлэх вэ гэдгээ тодорхойлох хэрэгтэй байна.



4. МОНГОЛЫН КОМПАНИУДЫН ОЙЛГОЛТУУДЫН ТУХАЙ СУДАЛГАА – ТХЗ–УУД НЬ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА КОМПАНИЙН АМЖИЛТЫГ НЭГТГЭХ БОЛОМЖ БОЛОХ НЬ

2017 оны хавар Монголын Компанийн Засаглалын Хөгжлийн Төв (КЗХТ) 49 компаниас КНХ–ын тухай ойлголт ба ТХЗ–уудтай тэдний зүгээс уялдах, хамтрах боломжуудын тухай асуулга авсан юм. Үүнээс гадна компанийн өгсөн хариултуудын ерөнхий утга агуулгуудыг тодруулахын тулд 5–н Бизнесийн Холбоо ба 5–н ТББ–уудаас мөн ярилцлага авсан болно.

Үрдүнгээс харахад компаниуд КНХ ба ТХЗ–ууд нь нэмэлт үнэ цэнэ бий болгох боломжтойг ойлгож байгаа бөгөөд ихэнх нь хариуцлагатай бизнесийн зан төлвийг дагах эрмэлзэлтэй гэжээ. Гэхдээ олон компанийн төлөөлөгчдийн илэрхийлснээр Монголын бизнесийн ертөнц, хууль эрх зүйн ба улс төрийн орчин, мөн Монголын олон нийтээс хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааг бараг таньж ойлгож авдаггүй зэрэг нь компани илүү үүрэг хүлээхэд саад болдог байна. Тиймээс судалгаанаас Монголд ТХЗ–уудын ирээдүй гүн гүнзгий, ил тод, урт хугацааны бизнесийн, төр засгийн болон иргэний нийгмийн хамтын ажиллагаанаас хүчтэй хамаарах бөгөөд хувь хамаарагч бүлгүүд тус бүрийн үүрэг ТХЗ–уудыг амжилтын түүх болгон хувиргахад бас багагүй чухал үүрэгтэй болох нь харагдаж байна. Итгэлцэл дээр суурилсан яриа хэлцэл нь Дэлхийн Зорилтуудыг ажил хэрэг болгоход гол хүчин зүйл мөн юм: судалгааны дүнгээс харахад ТХЗ–ууд нь өмнөх оролдлогоосоо ялгаатай, ирээдүйтэй санал санаачлага бөгөөд хувь нэмрээ оруулахад бэлэн байгаагаа компаниуд илэрхийлсэн байна.


4.1. КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА – ТАНИЛ ХАНДЛАГА ҮЛ ИТГЭХ ХАНДЛАГА ХОЁР УУЛЗСАН НЬ

Дараагийн хэсэг хэрхэн КНХ/хариуцлагатай/тогтвортой бизнесийн боломжуудыг Монголын компаниуд ойлгож хүлээж авч байгаа болон компанийн төлөөллүүд ямар ямар компанийн дотоодын болон ерөнхий саад бэрхшээл, хязгаарлалтуудыг тодорхойлсныг тусган харуулна. Мөн энэ хэсэгт компаниуд Монголын нийгэмд идэвхтэй, найдвартай тоглогч болоход ямар нөхцлүүд тодорхойлдог болохыг компаниудын төлөөллүүдийн хариулснаас харж болно.

4.1.1. КНХ /хариуцлагатай бизнесийг тодорхойлох нь

Нийт 49–н төлөөллөөс 46 нь КНХ гэдэг нэр томъёог мэддэг гэж хариулсан бөгөөд тэдний өөрсдийн бизнестэй уялдаатайгаар хариуцлагатай бизнес гэж юу болохыг ойлгож байгаа гэж хариулсан байна.

Компанийн нийгмийн хариуцлагыг ерөнхийлөн тодорхойлох нь




Зураг 3: Та ерөнхийд нь КНХ/хариуцлагатай/тогтвортой бизнесийг хэрхэн тодорхойлох вэ?

Ерөнхий түвшиндээ оролцогчдын 28% нь КНХ-ыг Монгол улсын байгаль орчин ба нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах арга хэмжээнүүд гэж тодорхойлсон байна. 14% нь гэм хор, хохирол учруулахгүй байх нь гол нь чухал гэж үзсэн байна. Харин ердөө 13% нь

КНХ бол компанийн бизнесийн суурь болно гэж хариулсан байгаа юм. Эцэст нь хэдхэн оролцогч КНХ-ыг ашгийн бус үйл ажиллагаа, эсвэл зүгээр л нэр хүндэд зориулагдсан үйл гэж тодорхойлсон байна.

КНХ-ыг бизнестэй уялдуулах нь




Зураг 4: Та КНХ/хариуцлагатай/тогтвортой бизнесийг өөрийн бизнесийн сектортэй уялдуулан юу гэж тодорхойлох вэ?

Компанийн өөрийн үйл ажиллагаатай уялдуулаад байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулан өндөр чанартай бүтээгдхүүн санал болгохыг дийлэнх нь дурдсан байгаа. Оролцогчдын дөрөвний нэг нь өөрсдийн ажиллаж амьдарч байгаа нийгмийн хэсэгтэйгээ ашиг өгөөжөө хуваалцах нь КНХ-ын гол үйл ажиллагаа гэж үзсэн байна. 9% нь өөрсдийгөө жишиг загвар болж ёс зүйн хэм хэмжээг зөвхөн бизнестээ бус бизнесээс гадуур ч түгээн тараах нь тэдний үүрэг гэж тодорхойлсон. Татвараа цагтаа төлөх нь хариуцлагатай бизнесийн бас нэг чухал шинж гэж үзэж ач холбогдол өгч байгаа оролцогчид бас байлаа.

4.1.2. КНХ /хариуцлагатай бизнесийн ач холбогдол

29 компанийн төлөөлөгч КНХ-ыг Монголд маш чухал ач холбогдолтой гэсэн бол 17 нь чухал, харин 3 оролцогч тодорхой хэмжээнд чухал гэж хариулсан байна. КНХ нь Монголд яагаад чухал болохыг асуухад олон оролцогч улсын ерөнхий хөгжил ба нийт хүн амын тогтвортой ирээдүйд эерэг нөлөөтэй гэж үзсэн байна. Цөөн оролцогчид хариуцлагатай бизнес нь компанийн үр дүнд эерэг нөлөөтэй гэж хариулсан байна.

КНХ яагаад чухал вэ




Зураг 5: КНХ нь яагаад Монголын нийгмийн ирээдүйн хөгжилд ач холбогдолтой вэ?

4.1.3. Компанийн өнцгөөс Монгол дахь КНХ-ын түвшинг тодорхойлох нь

Монголд КНХ-ын ойлголт, эсвэл хариуцлагатай бизнесийн ойлголт ямар түвшинд байгаа вэ гэсэн асуултанд компаниудын төлөөллүүд ерөнхийдөө доогуур түвшинтэй байгаа гэж онцолсон бөгөөд дийлэнх нь (26) тааруухан, 19 нь эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарч байнга

өөрчлөгдөж байдаг гэсэн бол 2-хон оролцогч Монголд сайн хөгжсөн гэж хариулсан байна.

Монголын Нийгмийн Хариуцлагын түвшин




Зураг 6: Таны бодлоор Монголд КНХ/хариуцлагатай/тогтвортой бизнесийн соёл ямар түвшинд байгаа вэ?

Шалтгаануудыг асуухад 16 оролцогч Монголд КНХ-ын соёлын хөгжил дөнгөж ойрын жилүүдэд л эхэлж байгаа гэсэн байна. Мөн зарим төлөөлөгчид ерөнхийдөө одоогоор томоохон компаниуд л КНХ-г тогтмол хэрэгжүүлдэг гэж тодорхойлсон. Энэ хүрээнд төлөөллүүд Монголын компаниуд илүү идэвхтэй байхад олон талын бэрхшээлүүд байдгийг дурдсан юм. Хамгийн чухал нь мэдээлэл, мэдлэг ба туршлага дутуу, мөн өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарч санхүүгийн нөөц боломж хангалтгүй

байгаа нь их нөлөөлж байгааг онцолсон. Бас төр засгаас дэмжлэг ба зөвлөмж чиглэл үгүйлэгдэж байгааг хэлээд ил тод байдал хангалтгүй, мөн Монгол дахь хүнд суртал тэдэнд сөргөөр нөлөөлж байгааг дурдсан байна. Судалгаанаас компаниудын зүгээс нийт хүн амын дэмжлэг КНХ/хариуцлагатай/тогтвортой бизнесийн үйл ажиллагаанд нь хангалтгүй байдаг гэж үздэгийг харж болох ба улс төрийн шийдвэр гаргагчид болон нийгмийн дийлэнх олонхийн сэтгэл зүй бэлэн биш байгааг бас дурдсан.

Монголын КНХ дахь саад бэрхшээлүүд



Зураг 7: Монголд КНХ/хариуцлагатай/тогтвортой бизнесийн түвшинг сайжруулахад учирч буй ямар гол саад бэрхшээлүүд байна вэ? [Хэд хэдэн хариулт]

Төлөөлөгчдийн дийлэнх нь компаниудыг үүднээс одоогийн байгаа хууль зүйн орчин илүү сайн дэмжих, хянах болон урамшуулах сайжрах ёстой гэж үзсэн байна.


Хууль эрх зүйн орчин



Зураг 8: Одоогийн байгаа хууль эрх зүйн орчин КНХ/хариуцлагатай/тогтвортой бизнесийн түвшинг бэхжүүлэхэд тохиромжтой байгаа уу, эсвэл өөрчлөлт шаардлагатай гэж үзэж байна уу?

Монголд ерөнхийдөө КНХ/ дахь асуултаас харагдаж байгаа бөгөөд цөөн хариуцлагатай/тогтвортой бизнесийн тухай оролцогчид хуульд асуудал байгаа бус харин ойлголт, мэдлэг байхгүй, тиймээс ч дэмжлэг талбар дээрх компаниудын идэвхгүй байдал бас алга байгааг хууль эрх зүйн орчны хоёр асуудал мөн юм гэж хариулсан байна.

Хууль эрх зүйн орчин КНХ-д хэрхэн нөлөөлдөг вэ




Зураг 9: Тодруулбал, та одоогийн хууль эрх зүйн орчин ба түүний хэрэгжүүлэлт КНХ/хариуцлагатай/тогтвортой бизнест хариуцлагатай хандаж буй компаниудыг дэмжиж байна гэж үздэг үү, эсвэл тэдэнд олон нийтийн зүгээс дэмжлэг урамшуулал байхгүй байгаа учраас компаниуд идэвхгүй байна гэж үзэж байна уу?

4.1.4. Хэн КНХ-ыг хэрэгжүүлэх ёстой вэ, хэн үр өгөөжийг нь хүртэх вэ?

Монголын компаниудын КНХ/хариуцлагатай/тогтвортой бизнесийн үйл ажиллагаануудаас хэн хамгийн ихээр үр өгөөжийг нь хүртэх вэ гэсэн асуултанд төлөөлөгчдийн 37%

нь нийт Монголын олон нийт, нийгэм ба эмзэг бүлгүүд, харин 15% нь компанийн ажилчид, 13% нь өөрсдийн арга хэмжээнүүдээс компани ба түүний бэлтгэн нийлүүлэгчид хамгийн ихээр үр өгөөжийг хүртэнэ гэсэн байна. Ирээдүй үеийнхэн (8%) ба байгаль орчин (7%) зэрэг хариултууд бага хувь эзэлсэн.

КНХ хэнд хамгийн үр өгөөжтэй байх ёстой вэ



Зураг 10: Хэн компаниудын хэрэгжүүлж буй КНХ/хариуцлагатай/тогтвортой бизнесийн үйл ажиллагаануудаас хамгийн ихээр үр өгөөж хүртэх ёстой вэ? [Хэд хэдэн хариулт]

Аль оролцогч тал Монголын эдийн засаг, байгаль орчин ба нийгмийн нөхцөл байдлыг сайжруулахад хамгийн ихээр хариуцлага хүлээх ёстой гэсэн асуултанд компаниуд хамтарсан үүрэг хариуцлага байх ёстойг тэмдэглэсэн ч 19 төлөөлөгч төр засгийг ахиц дэвшлийг бий болгоход чухал үүрэгтэй, 17 төлөөлөгч төр засгийг бүхэлдээ маш чухал гэж үзсэн байна. Төр засаг, засаг захиргаа яагаад чухал тухайд тодруулахад тэд тодорхой бодлого, төлөвлөгөөгөөр хангах үүрэгтэй, мөн тэдний үйл ажиллагаа, дэмжлэгээр компаниудын КНХ-д хүлээх үүрэг илүү хүчтэй,

санаачлагатай болно гэсэн байна.

Нийт 49-н төлөөллөөс 8 нь л компаниуд ба тэдний бизнесийн түншүүд чухал тоглогчид гэж үзсэн бол талаас илүү нь Монгол нь улс орны хувьд урагшилж хөгжихөд бизнес маш чухал гэж үзсэн байна. Компанийн зүгээс дүгнэхэд ТББ-ууд болон Бизнесийн Холбоод бага үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хэрэглэгчид ба олон нийт тодорхой хэмжээнд чухал үүрэгтэй гэсэн байна.

Эдийн засаг, нийгэм ба байгаль орчны нөхцөл байдалд хамаарагч талуудын үүрэг ач холбогдол




Зураг 11: Монголын эдийн засаг, нийгэм ба байгаль орчны нөхцөл байдлын хувьд авч үзвэл аль хамаарагч тал хамгийн чухал үүрэг хариуцлага гүйцэтгэнэ гэж та үзэж байна вэ, яагаад?

Ер нь хамаарагч талууд өөрсдийн үүрэг хариуцлагаа ухамсарлаж байгаа эсэхийг тодруулахад оролцогчдын дийлэнх нь компаниуд ба тэдний бизнесийн түншүүд өөрсдийн үүргээ маш чухалд үздэг (11) эсвэл нэлээд чухалд үздэг (28) гэж хариулсан

байна. Мөн олонх нь (6 сайн ухамсарласан, 25 тодорхой хэмжээнд) засаг захиргааны тухайд төстэй хариултуудыг өгчээ. Харин хэрэглэгчид ба нийт хүн амын тухайд нэлээд эргэлзээтэй хариулсан, эсвэл бүр байр сууриа илэрхийлж чадалгүй орхисон байна.

Хамаарагч талууд өөрсдийн үүрэг хариуцлагад хэр нухацтай ханддаг вэ(N=48)



Зураг 12: Сүүлийн асуулттай уялдуулаад хамаарагч талууд өөрсдийн үүрэг хариуцлагыг ухамсарлаж нухацтай ханддаг гэж та боддог уу?

Олон улсын хандлагатай төстэй нь хэрэглэгчид ирээдүйд харилцагчид, боломжит ажилтан ажилчид, эсвэл хэвлэл мэдээллийн оролцогчдын хувиар илүү хүчтэй үүрэг гүйцэтгэнэ гэдгийг компанийн төлөөллүүд илэрхийлсэн юм: 48 оролцогчоос 40 нь хэрэглэгчид Монголын ирээдүйн нийгэмд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ гэж үзсэн байна.

4.1.5. Компанийн түвшинд хариуцлагатай бизнесийг удирдах нь – Бодлого ба хэрэгжүүлэлт

Хэтийн зорилго/эрхэм зорилго болон үйл ажиллагааны дүрэмтэй байх нь хариуцлагатай/тогтвортой бизнесийн эхлэл гэж тооцогдох нь бий. Түүний дагуу хариу өгсөн компаниудын 46 нь тэдний компани нь өөрийн компанийн үнэт зүйлсийг тодорхойлсон хэтийн зорилго/эрхэм зорилго болон үйл

ажиллагааны дүрэмтэй гэж хариулжээ. 35 нь КНХ/тогтвортой бизнес нь хамгийн чухал зүйлсийн нэг гэж хариулсан ба 35 нь ойрын хугацаанд үүнийг өөрсдийн гол үнэт зүйлсд багтаана гэж хариулжээ. Компанийн төлөөлөгчдийн 2/3 нь албан ёсны бодлогодоо бизнесийн ёс зүйн дүрэм болон дагаж мөрдөх тухай албан ёсоор оруулсан эсвэл төлөвлөж байгаа гэж хариулсан байсан бол 55% нь бизнесийн ёс зүйн дүрэм болон дагаж мөрдөх тухайг хариуцсан менежментийн хүн байгаа гэж хариулсан. Судалгаанд оролцогчдын 50% нь ёс зүйн дүрэм харгалзсан удирдлагын систем бий гэж хариулсан байсан бол 25% нь бүрэн эсвэл зарим талаар бизнесийн ёс зүйн дүрэм болон дагаж мөрдөх менежментийг компанидаа баримтжуулдаг гэсэн байна. Одоогийн байдлаар судалгаанд оролцсон компаниудийн 17% нь Компанийн нийгмийн хариуцлагын / Тогтвортой байдлын тухай

тайланг хэвлэн гаргадаг байна. Харин 20% нь ирээдүйд тайлан гаргах төлөвлөгөөтэй байгаа.

Засаглал, эдийн засгийн тогтвортой байдлын асуултаас гадна, нийгмийн болон байгаль орчны хариуцлага, ямар нэгэн сөрөг нөлөөллийг бууруулах зарчмуудын талаар тодорхой байх нь тогтвортой, үр өгөөжтэй өсөлтөнд нөлөөтэй 2 дахь чухал алхам гэж асуулганд оролцогчид үзсэн. Энэ утгаараа, судалгааны үр дүнд компаниудын ихээхэн хувь нь нийгмийн асуудлууд дээрх бодлогуудад анхаарал тавьдаг байна. Судалгаанд оролцогчдын 61% нь дор дурьдсан нийгмийн асуудлууд дээр удирдлагын систем байгаа эсвэл хэрэгжүүлэх арга хэмжээ авах төлөвлөгөөтэй байгаагаа дурьджээ. Харин 48% нь нийгмийн асуулт хариуцсан менежментийн ажилтан байгаа гэж хариулжээ.


Компанийн бодлогод хамрагдаж байгаа нийгмийн асуудлууд



Зураг 13: Дараах ямар нийгмийн асуудлуудыг танай компанийн бодлогод тусгасан байдаг вэ?

Үүний зэрэгцээ, Судалгаанд оролцогчдын талаас доош хувь нь (48%), албан ёсны байгаль орчны бодлого байгаа эсвэл Ийм бодлогыг бий болгох төлөвлөгөөтэй байгаагаа хэлжээ. Судалгаанд оролцогчдын тал хувь нь байгаль орчны асуудал эрхэлсэн

менежментийн хүн байдаг гэж хариулсан. Байгаль орчны дүрэмтэй (16 компани буюу 33%) компаниуд дунд ихэнх нь Бодлоготой эсвэл хамгийн чухал асуудлууд дээр хамаарах үйл явц байгаа гэж хариулсан юм.

Компанийн бодлогод хамрагдаж байгаа байгаль орчны асуудлууд (N=16)

Зураг 14: Танай компанид байгаль байгаль орчны албан бодлого байдаг уу, байдаг бол тодорхойлно уу?

Асуулганд оролцсон компаниудын 94% нь байгаль орчны бодлоготой мөн Байгаль орчны менежментийн системтэй гэсэн бол оролцсон компаниудын 21% нь ийм тогтолцоог бий болгох төлөвлөгөөтэй байна. Бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээний асуудлууд дээр ярилцлаганд орсон компаниудын зөвхөн 27% нь Компанийн нийгмийн хариуцлагын/ тогтвортой байдлын бодлоготой гэсэн бөгөөд 16% нь ийм бодлоготой болох төлөвлөгөөтэй байгаагаа дурьджээ. КНХ /Тогтвортой байдлын бодлого байдаг компаниуд Ажлын нөхцөл, Ялгаварлан гадуурхах, Эрүүл ахуй, аюулгүйн ажиллагаа, Авилга, хээл хахууль, Байгаль орчин гэсэн нөхцөлүүдийг хамарсан байна. Үүний зэрэгцээ, оролцогчидын зөвхөн 39% нь Бэлтгэн нийлүүлэлтийн бодлогоо нийлүүлэгчиддээ мэдээлсэн гэдэгтээ итгэлтэй байсан. Оролцсон 49 компанийн 30 нь бизнесийн түншүүддээ

өөрийн компанийн КНХ/Тогтвортой байдалын тухай мэдээлэл өгдөг, эсвэл татан оролцуулдаг гэж хариулжээ. Ярилцлаганд орсон компанийн төлөөлөгчдийн тал хүрэхгүй хувь нь (23 компани буюу


47%) нь өөрийн бизнесийн үйл ажиллагаанд шууд холбоотой биш арга хэмжээний талаарх асуултанд хариулт өгсөн. Байгаль орчны асуудлууд яригдахад, Эдгээр 23 компанийн 44% нь мод тарих гэх мэт хүрээлэн буй орчны

төслийг дэмждэг, 21% нь Улаанбаатар хотын агаарын бохирдолтой тэмцэх ажилд хувь нэмрээ оруулахыг зорьдог. Нийгмийн асуудлын тухайд 22% нь сан болон хандиваар спорт, боловсролд дэмжлэг үзүүлдэг мөн 17% нь ажилчид, ажилчдын гэр бүл, эсвэл олон нийтийн амьдарч байгаа газарт дэмжлэг үзүүлдэг байна. Ярилцлаганд орсон компаниудын 83% нь хариуцлагатай бизнес гэдэг үүднээсээ байнга буюу хааяа Орон нутгийн, бүс нутгийн, үндэсний төслүүдийг болон бусад холбогдох үйл явдлыг дэмждэг байна.

4.1.6. Компаниуд болон хамаарагч талууд

Судалгаанаас харахад, Монгол компаниудын дийлэнх хувь нь тэдний КНХ/ хариуцлагатай/тогтвортой бизнес хийх чармайлт нь ажилчид, харилцагч болон бусад хамаарагч талуудад анзаарагддаггүй гэж итгэдэг байна. Бүх судалгааны группын дунд санал асуулгын хариултын хамгийн том хувь нь дээрх зүйлс нь зарим талаараа ач холбогдолтой гэж хариулсан байна. Олон улсад ажиглагддаг жишгийн дагуу харилцагч нар болон олон нийт дээрх зүйлсийг “Бизнес онцгой чухал” болон “маш чухал” гэсэн ангилалд багтаажээ.

Таны бизнестэй шууд уялдаатай КНХ/тогтвортой байдлын үйл ажиллагаануудад ялгаатай хамаарагч талууд ямар ач холбогдол өгдөг вэ?



Зураг 15: Таны бизнестэй шууд уялдаатай КНХ, тогтвортой байдлын үйл ажиллагаануудад ялгаатай хамаарагч талууд ямар ач холбогдол өгдөг гэж та боддог вэ?

Бага хэмжээний үүрэг ажилчдад хамаарч байна

Дээр дурьдсанчлан олон компаниуд өөрсдийн ажилчдыг чухал оролцогч гэж үздэг бөгөөд компанийн үнэт зүйлс ба бодлого нь бичгээр байдаг гэж мэдэгдсэн байна. Гэвч санал асуулгад оролцогсдын зөвхөн тал нь КНХ эсвэл тогтвортой байдлын талаар ажилчдаа сургадаг, мэдээллээр хангадаг буюу тийм зүйл хийхээр төлөвлөж байгаа гэжээ. Компаниудын 37% нь л дээрх асуудлын талаар өөрсдийн ажилчидтайгаа санал хүсэлтийн хайрцаг, санал асуулга гэх мэт аргаар харилцаа тогтоодог байна. Эдгээр компаниудын 83% нь ажилчдынхаа сайн дурын ажлыг урамшуулдаг эсвэл урамшуулна гэж хариулжээ.

Ажилчид болон удирдлагад ямар төрлийн сургалт явуулмаар байгааг асуухад, компаниудын 75% нь эрүүл ахуй ба аюулгүй байдал, 72% нь үйл ажиллагааны дүрэм, 63% нь байгаль орчны менежмент ба 54% нь нийгмийн асуудал, авилгын эсрэг болон ёс зүйн талаар гэж хариулсан байна. Ажилчид болон менежерүүдийн зөвхөн 40% нь

байгууллагаас гадуур сургалтад суусан буюу суухаар төлөвлөж байгаа гэсэн байна.

Үүний зэрэгцээ хариуцлагатай бизнесийн хүрээг тэлэх талаар Монголын компаниуд өөрсдийн ажилчдад хязгаарлагдмал үүрэг хамааруулдаг байна: Зөвхөн 16% нь хариуцлагатай бизнес хөгжүүлэх талаар ажилчдын гаргасан шинэ санаа нь компанийн ТУЗ эсвэл хувь нийлүүлэгчийн түвшинд дэмжигдэгдвэл цаашид хэрэгжүүлэх болно гэж хариулжээ.

4.2. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД – БҮХ ХАМААРАГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ШААРДСАН ХАРИУЦЛАГАТАЙ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ МОНГОЛ ДАХЬ ШИНЭ ХҮЧ

Санал асуулгад оролцсон компаниудын ихэнх нь КНХ/хариуцлагатай бизнес гэх ойлголтыг мэддэг боловч цөөхөн оролцогч компаниуд Тогтвортой Хөгжлийн Зорилтуудыг шууд мэдэж байна: санал асуулгад оролцсон 49 хариултаас 32 нь Тогтвортой Хөгжлийн Зорилт гэх нэршлийг мэднэ эсвэл дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт гэдгийг сонссон

гэж хариулжээ. Гэвч зөвхөн 17% нь ТХЗ–ийн талаар сайн мэдээлэлтэй гэж хариулсан байна.

Тогтвортой хөгжлийн зорилтод хүрэх замд Монгол улсын гаргаж буй ахицын талаар асуухад, санал асуулгад оролцогсод нэлээд шүүмжлэлтэй хандаж, нэг ч компанийн төлөөлөл хангалттай ахиц гаргасан гэж дүгнээгүй бөгөөд 37% нь гаргасан ахиц нь хангалтгүй буюу саармаг, 26% нь шийдэж чадахгүй гэж хариулсан. Гэвч 17 зорилтын талаар нэг бүрчлэн асуухад, асуулгад оролцогсод зарим хэсэгт нь эерэг хариулт өгсөн болно. Оролцогсдын хорь нь жендерийн эрх тэгш байдлыг хангахад (#5) хангалттай ахиц гарсан, арав буюу түүнээс дээш нь Чанартай боловсролыг

дэмжих (#4), Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах (#6), Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих (#11), Энх тайван, шударга ёсыг цогцлоох (#16) болон Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх (#17) зорилтуудад ахиц гарсан гэж дүгнэжээ.

Харьцуулахад, Ядуурлыг устгах (#1) зорилт хамгийн их эргэлзээтэй тулгарсан ба асуулгад оролцсон компаниудын 70% нь энэ талбар дээр гаргасан Монгол улсын ахиц хангалтгүй гэж дүгнэсэн байна. Эрүүл мэндийг дэмжих (#3), Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох (#8), Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх (#9), Уурын амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах (#13) гэх мэт зарим зорилтуудын ахицыг хоцорч яваа гэсэн байна.

ТХЗ–уудад хүрэхэд Монгол улсын гаргаж буй ахиц дэвшил



Зураг 16: ТХЗ тус бүр дээр Монгол улс өнөөдөр ямар ахиц дэвшил гаргаж байгааг та үнэлнэ үү?

4.2.1. Монгол улсад тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад компаниудын гүйцэтгэх үүрэг


Сонирхолтой нь, компаниуд ТХЗ–д оруулж буй өөрсдийн ахиц дэвшилийг, Монгол улсын ахиц дэвшилээс илүү сайн хувь нэмэр оруулж байгаа гэж үнэлсэн (37% нь ахиц дэвшил ядуу буюу саармаг байна гэж дүгнэсэн)

Компанийн түвшинд (N=48), судалгаанд оролцогчдын зөвхөн 10% нь хөгжлийг муу байна гэж дүгнэсэн бол 35% нь хөгжлийг саармаг гэж дүгнэж байна. 37% хөгжлийг сайн. 17% нь шийдэж чадаагүй. Компаниуд ялангуяа Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох #8, Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх #7, Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх #9 гэсэн зорилтууд

дээр тэд сайн ахиц дэвшил гаргасан гэж дүгнэж байна. Хариуцлагатай хэрэглээг дэмжих #12, Эрүүл мэндийг дэмжих #3 гэсэн

зорилтууд дээр нэлээн хэдэн компаниуд маш сайн ахиц дэвшил гаргасан гэж дүгнэсэн.

ТХЗ–уудыг хангахад компаниудын гаргаж байгаа ахиц дэвшлүүд




Зураг 17: ТХЗ тус бүр дээр компаниуд өнөөдөр ямар ахиц дэвшил гаргаж байгааг та үнэлнэ үү? (Боломжтой бол)

Энэхүү асуулга нь Монгол дахь ТХЗ хэрэгжилтийн байдлыг тооцохоос гадна, компаниуд дэлхийн зорилтод уялдан ажиллаж чадаж байгаа эсэх, тэдний өмнө тулгарсан тулгамдсан асуудлууд болон боломжууд ямар байгааг харахыг зорьсон юм. Нээлттэй асуултуудад бизнесийн бүлгүүд болон хувь компаниуд ТХЗ–уудыг хангахад ямар үүрэг гүйцэтгэж чадах вэ гэсэн асуулт орсон байсан. Ёс зүйн үндсэн дээр зөв компанийн бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах гэдэг хариулт хамгийн их буюу (21%), хууль

дагаж мөрдөх, ил тод байх, татвар төлөх (11%), ногоон үйлдвэрлэл мөн байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн (10%), ТХЗ–г хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг өгөх, ажилчдыг сургах /урамшуулах, эерэг хандлага үүсгэх, мөн хошуучлах тус бүр (8%) гэж гарсан байна. Итгэлцэл, хамтын ажиллагааг илүү өндөр түвшинд хүргэх нь олон улсын тогтвортой хөгжлийн зорилтод оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой гэж гарсан байна. (Доорх 4.3 хэсгийг үзнэ үү.)



ТХЗ–д хүрэхэд бизнесийн хүрээнийхэн болон компанийн гүйцэтгэх үүрэг



Зураг 18: Ерөнхийдөө бизнесийн хүрээнийхэн бие даасан компани ТХЗ–уудыг хангахад ямар үүрэг гүйцэтгэж чадах вэ?

Компанийн зүгээс хариуцлагатай /тогтвортой бизнес эрхлэх, ТХЗ–г хэрэгжүүлэхэд ямар урамшууллууд хэрэгтэй вэ гэсэн асуултанд компанийн төлөөлөгчид санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэгийн талаар дурьдсан ба илүү их дурьдагдсан урамшууллууд нь мөнгөн шагнал мөн хууль эрх зүй, улс төрийн орчинг бизнест ээлтэй болгох саналууд байлаа. Ярилцлаганд оролцсон компаниудын ихэнх нь татвар бууруулах, татвараас чөлөөлөх урамшууллыг дурьдсан байсан. Энэ нь тэдний хүчин чармайлтыг хүлээн зөвшөөрч, тэдэнд шууд шагнал олгож байгаа

хэрэг гэж тэд үзсэн юм. Судалгаанд оролцогчид тогтвортой эрх зүйн орчин шаардлагатай байгааг давтан хэлж байсан


ба тогтвортой бизнес болон ер нь тогтвортой хөгжлийг дэмждэг улс төрийн тогтолцоо хэрэгтэй байгааг олонтаа дурьдаж байсан. Мөн олон нийтийн дунд ТХЗ/Дэлхийн зорилтуудын ач холбогдол, энэ талаарх ерөнхий мэдлэг, мэдээллийг өгөх арга хэмжээ, сургалтуудыг өргөнөөр зохион байгуулах шаардлагатай байгааг компанийн төлөөлөгчид дурьдаж байв.



Зураг 19: Таны бодлоор ТХЗ–уудад хүрэхэд компаниуд оролцох ямар урамшуулал, боломжууд байна вэ?

ТХЗ–уудыг хэрэгжүүлэхэд компанийн өмнө тулгарах бэрхшээлүүд нь төрийн захиргааны үйл ажиллагаа болон олон нийтийн хандлагаас үүдэлтэй гэж компаниудын төлөөлөл тайлбарлаж байна. ТХЗ–ыг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн орчин, мэдлэг, мэдээллийн дутмаг байдал саад учруулж байна. Мөн өнөөгийн эдийн засгийн хүндрэлтэй байдал

сөргөөр нөлөөлж байна гэж хариулсан байна. Судалгаанд оролцогчдын цөөхөн хувь нь ТХЗ–г хэрэгжүүлэхэд компанийн хувьд ямар нэгэн томоохон саад бэрхшээл байхгүй гэсэн хариулт өгсөн байна. ТХЗ–д олигтой ахиц дэвшил гарахгүй байгаагийн шалтгааныг компанийн санаачлага дутагдалтай байгаатай холбоотой гэж тэд үзэж байна.




Зураг 20: ТХЗ–уудыг хангахад компаниудыг оролцоход ямар саад бэрхшээлүүд байна вэ? [Хэд хэдэн хариулт]

4.2.2. ТХЗ–уудад хувь нэмрээ оруулахад компаниудад юу сэдэл болох вэ?

Компаниуд олон асуудлууд болон саад бэрхшээлийг дурдаж байсан ч, тэдний ихэнх нь олон улсын энэ зорилтууд Монголд улс болон тэдний бизнест илүү их ашиг, боломжийг авчирна гэсэн эерэг хандлагатай

байсан. Нээлттэй асуултанд, компаниуд ТХЗ–г ирээдүйтэй үйл явц гэж харж байгаагаа дурьдсан бөгөөд асуулганд оролцогчид Тогтвортой хөгжлийн ерөнхий ач холбогдлыг, мөн ирээдүйд ТХЗ–г өргөн хүрээний дэмжлэг авах үйл явц гэж онцолсон байна.

ТХЗ–ийн талаарх компанийн байр суурь



Зураг 21: Та ТХЗ–уудыг компанийг орлцуулахаар шахаж байгаа бас л нэг төслүүдийн нэг гэж үзэж байна уу эсвэл өмнөх санаачлагуудаас ялгаатай, ирээдүйтэй үйл явц гэж үзэж байна уу?

Судалгаанд оролцогчдын тал хувь нь ТХЗ–ууд ямар боломжуудыг тэдэнд авчирч болох талаар мэдэхгүй/ойлголтгүй эсвэл асуултанд хариулаагүй байсан. Үүнийг урд нь дурьдсанчлан асуулганд оролцогчдын ТХЗ–ийн талаарх дэлгэрэнгүй мэдлэг дутмаг байгаатай холбон тайлбарлаж болно.

Тогтвортой бизнесийн ямар уйл ажиллагаа компаниудад богино болон урт хугацаанд эерэгээр хувь нэмрээ оруулж болох вэ гэсэн асуултанд ахиад ярилцлаганд оролцогсодын зөвхөн тал хувь нь хариулсан байна. Энэ нь ТХЗ–гийн тухай практик мэдлэг компанийн түвшинд ямар бага байгааг бататгаж

байна. Байгаль орчныг хамгаалах, ногоон бүтээгдэхүүнийг хөгжүүлэх санаа хамгийн их санал авсан юм. Үүний дараа компанийн нөлөөлөл ба стратегийг илүү сайн уялдуулах боломж орж байна. Цөөн тооны компаниуд бизнесийн ёс зүйн талаарх мэдлэг, сургалтыг дотооддоо болон гадаадад өгөхийг ач холбогдолтой арга хэмжээ гэж харж байна.

Бизнесийн үр дүнд сайнаар нөлөөлөх тогтвортой/хариуцлагатай арга хэмжээнүүд



Зураг 22: Ямар КНХ/хариуцлагатай/тогтвортой бизнесийн үйл ажиллагаанууд танай бизнест богино ба урт хугацаандаа эерэгээр нөлөөлж амжилтанд хүргэнэ гэж та бодож байна вэ?

4.2.3.ТХЗ–ууд тус бүрийн Монгол улсад үзүүлэх ач холбогдол болон компаниудийн гүйцэтгэх үүрэг – Яагаад, Хэрхэн

Өмнө нь дурьдаж байсанчлан, компаниуд өөрсдийн ТХЗ–д гаргаж буй ахиц дэвшил, хувь нэмрээ Монгол улсын гаргаж байгаа ахиц дэвшлээс илүү гэж үнэлсэн байгаа. Задалж үзвэл компаниуд хариулахдаа (N=48), 15 компани ТХЗ–г ёс зүйн дүрмэндээ эсвэл эрхэм зорилго, алсын хараандаа нэгтгэсэн, 20 компани ойрын ирээдүйд нэгтгэхээр

төлөвлөж байгаа, харин 5 компани үндсэн баримт бичигт ТХЗ–ыг нэгтгэх ямар ч бодолгүй байгаа гэдгээ дурьдсан. Одоогийн байдлаар 6 компани өөрсдийн ажилчдын дунд ТХЗ–ийн талаарх мэдээллийг олгосон гэж мэдэгдсэн.

ТХЗ дундаас аль зорилтууд нь Монгол улсийн ерөнхий хөгжилд илүү хамаатай вэ гэж компанийн төлөөлөгчдөөс асуухад, Чанартай боловсролыг дэмжих #4, Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл #12 гэсэн зорилтууд хамгийн олон санал авсан байна:

| Хамгийн чухал | 2-рт чухал | 3-рт чухал | 4-рт чухал | 5-рт чухал |
|---|--------------------------------|---|---|---|
| #3 Эрүүл мэндийг дэмжих | #3 Эрүүл мэндийг дэмжих | #4 Чанартай боловсролыг дэмжих | #4 Чанартай боловсролыг дэмжих | #12 Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл |
| #9 Аж үйлдвэр, шинэ санаачлага ба дэд бүтэц | #4 Чанартай боловсролыг дэмжих | #12 Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл | #12 Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл | #8 Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох |
| #4 Чанартай боловсролыг дэмжих | #1 Ядуурлыг устгах | #6 Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах | #8 Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох | #11 Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих |

Зураг 23: 1–17 зорилтууд дундаас аль зорилтууд нь (5 зорилтыг эрэмблэн) Монгол улсад илүү хамаатай гэж та харж байна вэ? Яагаад?

Тогтвортой Хөгжлийн 17 зорилтуудаас танай бизнестэй хамгийн уялдаатай зорилтууд юу вэ гэж асуухад, хамгийн олон дурьдагдсан зорилтууд бол Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл #12, Инноваци болон дэд бүтцийг

хөгжүүлэх #9 зорилтууд байсан бөгөөд зорилт #12-ыг улс орны болон компанийн түвшний хувьд хамгийн хэрэгцээтэй зорилт гэж компаниуд дүгнэсэн байна.

| Хамгийн чухал | 2-рт чухал | 3-рт чухал | 4-рт чухал | 5-рт чухал |
|---|---|--------------------------------------|--------------------------------------|---|
| #3 Эрүүл мэндийг дэмжих | #8 Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох | #9 Инноваци ба дэд бүтцийг хөгжүүлэх | #12 Хариуцлагатай хэрэглээг дэмжих | #11 Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих |
| #8 Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох | #9 Инноваци ба дэд бүтцийг хөгжүүлэх | #12 Хариуцлагатай хэрэглээг дэмжих | #9 Инноваци ба дэд бүтцийг хөгжүүлэх | #12 Хариуцлагатай хэрэглээг дэмжих |
| #4 Чанартай боловсролыг дэмжих | #6 Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах | #7 Хямд, цэвэр эрчим хүч | #4 Чанартай боловсролыг дэмжих | #6 Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах |

Зураг 24: 1–17–н ТХЗ–уудаас танай бизнестэй хамгийн уялдаатай зорилтууд нь (дээд тал нь 5 хүртэл) аль вэ? Яагаад?


Дээр дурьдсан компаниудтай холбоотой ТХЗ–ийн боломжууд болон үр нөлөөнүүдээс гадна яагаад компаниуд ТХЗ–г хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулж байгаа эсвэл ТХЗ–г хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах төлөвлөгөөтэй байгаа тухай асуусан. Олон сонголттой асуултанд, судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь компанийн тогтвортой байдлын стратегийг боловсруулах, шинэ зах зээлд өргөжихийн тулд ТХЗ нь

нийгмийн ирээдүйн хэрэгцээ, бизнесийн стратегийн үйл ажиллагааг уялдуулах сайн арга хэрэгсэл гэж үзсэн байна. Мөн нэр хүндийн үр өгөөжийг бий болгох, ялангуяа хэрэглэгчид болон шинэ үеийнхний дунд итгэлийг олж авах нь чухал гэж 21% нь хариулсан бол, 12% нь ТХЗ–г дэмжиж буй бодит шалтгаан нь ТХЗ–ууд Монгол улсад ач холбогдолтой хэрэгтэй гэж онцолсон юм.





Компаниуд яагаад ТХЗ-д хувь нэмрээ оруулдаг вэ?



Зураг 25: Таны бодлоор ТХЗ-уудад компаниуд хувь нэмэр оруулж байгаа, эсвэл оруулахаар төлөвлөж байгаагийн гол шалтгаанууд юу вэ? Дээд тал нь 4 шалтгааныг тодорхойлно уу.

Танай компани ТХЗ-уудад ямар хувь нэмэр оруулж байгаа, эсвэл оруулахаар төлөвлөж байгаа вэ гэсэн олон сонголтод асуултанд компанийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг бууруулах зоримог зорилтуудыг хэрэгжүүлж байгаа, ТХЗ-уудад шийдэл болж чадах бүтээгдхүүн, үйлчилгээг шинээр гаргах, мөн тодорхой ТХЗ-уудад хүрэхэд дэмжлэг үзүүлэх олон нийтийн-хувийн хамтын ажиллагаа, өөр бусад хамтын ажиллагаануудыг бий болгохоор ажиллаж байгаа гэсэн хариултууд давамгайлж байсан. Судалгаанд оролцогчдын дунд

ТХЗ-г тогтвортой байдлын стратегийг сайжруулах боломж гэж харж байна гэсэн сонголтыг сонгосон нь дундаас доош байсан. Хариуцлагатай/тогтвортой бизнесийг тодорхойлох тухай асуулганд Филантропи нь үндсэн санаа байгаагүй ч, ТХЗ-г хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хандив, сайн дурын бусад хэлбэр нь том үүрэг гүйцэтгэдэг бололтой. Судалгаанд оролцогчдын дөнгөж гуравны нэг нь шийдлийг олоход санхүүгийн хувь нэмэр оруулах нь бизнес эрхлэгчдийн үндсэн үүрэг гэсэн хариултыг сонгосон байна.

ТХЗ–д компаниуд хэрхэн хувь нэмрээ оруулж байгаа эсвэл оруулах төлөвлөгөөтэй байна вэ?



Зураг 26: Танай компани ТХЗ–уудыг хангахад хэрхэн хувь нэмэр оруулж байгаа, эсвэл оруулахаар төлөвлөж байгаа вэ? Хамгийн тохирох 5 хариултыг сонгоно уу.

Монголд ТХЗ–уудыг хэрэгжүүлэхэд хамгийн чухал хувь нэмэр оруулж байгаа талууд хэн бэ гэсэн асуултанд, компанийн төлөөлөгчид хувийн болон төрийн хэвшлийн аль аль нь хамтран чухал хувь нэмэр оруулж байгаа гэсэн байна. Тодруулбал, судалгаанд оролцогчдын тал хувь нь төрийн захиргааны байгууллагууд нь компаниуд ба тэдний бизнес

түншүүдтэй дүйцэхүйц хувь нэмэр оруулж байгаа гэж дүгнэсэн байгаа юм. Судалгаанд оролцогчид бизнесийн холбоод, ТББ–ууд, хэрэглэгчид, олон нийтийн тухайд эерэг хандлагатай байгаагүй ч тэдний ерөнхий гүйцэтгэлийн талаар эерэг хандлагатай байна.

ТХЗ–уудыг хангахад хамгийн их хувь нэмэр оруулж байгаа талууд хэн бэ?




Зураг 27: Таны бодлоор ТХЗ–уудыг хангахад Монголд хамгийн их хувь нэмэр оруулж байгаа талууд хэн бэ?

4.3. Хамтын ажиллагаа, мэдлэг хуваалцах нь Тогтвортой Монгол (бизнес) –ийн ирээдүй

Компанийн төлөөлөгчдөөс Монгол улсын хувьд тогтвортой нийгэм бий болгоход хамгийн шаардлагатай үйл ажиллагааг тодруулан асуухад мэдлэг солилцох, хуваалцах гэсэн хариултыг төлөөлөгчид ихээр онцолсон байсан. Тухайлан судалгаанд оролцогчид хамтын ажиллагаа, яриа хэлэлцээрт их ач холбогдол өгч байна. 49 компаниас 46 нь ийм хэрэгцээ байгааг харж байгаагаа илэрхийлсэн ба хамаарагч талуудын хамтын

хариуцлага хэрэгтэйг дурьдсан юм. Илүү сайн, хамтын ажиллагаатай, КНХ/хариуцлагатай/ тогтвортой бизнесийн түвшин нь сайжрах нөхцлүүдийг хангах арга хэмжээнүүдийг Монголд хэн хариуцах, хэн манлайлах ёстой вэ гэсэн асуултанд Компанийн төлөөлөгчид компаниуд өөрсдөө болон Төрийн захиргааг хамгийн чухал бүлгүүд гэж харж байна. Компанийн төлөөлөгчид ТББ-ийн үүрэг нөлөө юу болохыг сайн мэдэхгүй байсан ч тэд улсын хэмжээнд ТББ болон нийт олныг чухал түншүүд гэж тодорхойлсон.

Хэн манлайлах ёстой вэ




Зураг 28: Монголд хамтын ажиллагаа хүчтэй байж КНХ, хариуцлагатай, тогтвортой бизнесийн түвшин сайжрахад хэн манлайлах арга хэмжээ авч, үүрэг хариуцлага үүрэх ёстой вэ?

Ямар арга хэмжээнүүд хамаарагч бүлгүүдийн хооронд хамтын ажиллагааг сайжруулан КНХ/хариуцлагатай/тогтвортой бизнесийн түвшинг ахиулахад хамгийн ихээр туслах вэ гэсэн асуултанд зохицуулалт, мэдлэг хуваалцах гэсэн хариултауд түгээмэл байсан. Судалгаанд оролцогчдын 20% нь төрийн захиргааны бодлогын амлалт,

төрийн захиргааны төв байгууллагаас манлайлал хэрэгтэй гэж харж байна. 17% нь мэргэжилтний мэдлэгийг түгээх хэрэгтэй гэж үзсэн байгаа. Олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх болон олон нийтийн арга хэмжээнүүд, түүнчлэн ил тод урамшууллыг компанийн төлөөлөгчид чухал гэж дурдсан.


КНХ-ын түвшинг сайжруулах, хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд авах шилдэг арга хэмжээнүүд



Зураг 29: Ямар арга хэмжээнүүд Монголд хамаарагч талуудын хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлж КНХ, хариуцлагатай, тогтвортой бизнесийн түвшинг сайжруулахад хамгийн ихээр туслах вэ?

Ямар арга хэмжээнүүд Монголд КНХ / дурьдсан байна. Гэсэн хэдий ч ТХЗ-ын хэрэгжилтийн талаарх асуултанд түвшинг сайжруулахад туслах ба/эсвэл үр цөөхөн компанийн төлөөлөл санал бодлоо өгөөжтэй байж болох вэ гэсэн асуултанд илэрхийлсэн байна. хамтарсан төсөл, хамтарсан сургалтыг

ТХЗ-уудад хамтран хүрэхэд авах арга хэмжээнүүд



Зураг 30: Таны бодлоор ямар арга хэмжээнүүдийг хамтран авч хэрэгжүүлснээр ТХЗ-уудыг амжилтанд хүргэх вэ?

Судалгаанд оролцогчдын 77% нь компанийн нийтлэг шийдлийг олох зорилгоор хамтын ажиллагааны арга хэмжээнд оролцох сонирхолтой байгаагаа илэрхийлсэн. ТХЗ-г хэрэгжүүлэхэд ямар үйл ажиллагаа байж болох вэ гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 20% нь эрх зүйн таатай орчин, судалгаанд оролцогчдын 35% нь бизнесийн салбарт өөрийн амлалтандаа эзэн байж, ТХЗ-ийн хэрэгжилт, хяналт-шинжилгээнд анхаарч, засаглалын стандартыг олон улсын мэргэжилтнүүдээс суралцан бие биенийхээ дунд туршлага хуваалцах замаар Монгол Улсын ирээдүйн хөгжилд хувь нэмэр оруулах хэрэгтэй гэж дурдсан юм.

4.4. Судалгаа – ТББ-уудын байр суурь

Компанийн ярилцлагын агуулгын хүрээнд ТББ-уудаас Монгол дахь КНХ ба ТХЗ-уудын түвшинг тодруулсан юм. ТББ-уудын хянагч ба ажиглагч, бас өмгөөлөн хамгаалагчийн хувьд гүйцэтгэх үүргүүд нь өнөөг хүртэл хөгжлийн үедээ явж байгаа учраас дөнгөж 5-н ТББ-тай ярилцлага хийх боломжтой байлаа. Гэхдээ тэд хамтын ажиллагааны ач холбогдол болон гуравдагч этгээдийн зүгээс өөрсдийн бодлыг илэрхийлсэн нь сонирхолтой болсон юм.

Бүх ярилцлага өгөгчид КНХ ба ТХЗ-уудын нэр томъёог мэдэж байсан бөгөөд хариуцлагатай бизнесийг компанийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах, мөн үүний зэрэгцээ нийгэмдээ буцаан хувь нэмрээ оруулах явдал гэж тодорхойлсон юм. Гэхдээ бүх оролцогчид ТХЗ-уудын зорилго, агуулгуудын тухай хангалттай мэдээлэл аваагүй гэсэн юм. Мөн бүгд КНХ-ыг Монголд тааруухан гэж үнэлсэн бөгөөд шалтгаан нь КНХ-ын мэдлэг мэдээлэл дутмаг, бас эдийн засгийн тогтворгүй байдалтай холбоотой гэжээ. Заримынх нь хэлснээр компаниудад “илүү сайн зүтгэл гаргах” санаачлага дутдаг бөгөөд КНХ ба хариуцлагатай бизнесийг

ердийн сурталчилгаа идэвхжүүлэлтийн хэрэгсэл, нэмэлт зардлын хэлбэр л гэж хардаг гэсэн юм. Үүний зэрэгцээ 4 оролцогч КНХ нь маш чухал, улс орны ирээдүйн хөгжлийн суурь мөн гэсэн бөгөөд хувь хүмүүст ёс зүй, зөв хүмүүжлийг төлөвшүүлэхэд шаардлагатай гэсэн юм. 5 оролцогч бүгдээрээ одоогийн хууль эрх зүйн орчинг сайжруулах хэрэгтэй гэсэн бөгөөд компаниудыг илүү хариуцлагатай бизнес хийхэд урамшуулал, сэдэл хэрэгтэй гэж хариулсан. Хариуцлагатай бизнесийн үр өгөөжийг хэн хамгийн ихээр хүртэх ёстой вэ гэж асуухад компаниуд болон Монголын нийгэм аль аль нь өгөөж хүртэх ёстой гэж оролцогчид хариулсан байна. Бүх хамаарагч талууд хамтран үүрэг хариуцлагуудаа үүрэлцэж байж Монголын эдийн засаг, нийгэм ба байгаль орчны нөхцөлийг сайжруулж чадна гэж 4 оролцогч дүгнэсэн байна. Аль оролцогч тал үүрэг хариуцлагаа нухацтай ухамсарлаж байгааг тодруулахад ТББ-ууд хэрэглэгчид ба олон нийтэд шүүмжлэлтэй хандсан юм. Мөн 3 оролцогч Монголын хэрэглэгчид компаниудыг илүү хариуцлагатай, тогтвортой бизнесийг ирээдүйд хийхэд хүргэж, түлхэж чадна гэдэгт эргэлзээтэй хандсан байна.

Нийт оролцогчид хамаарагч талуудын хамтын ажиллагаа, мөн тэдний хоорондын итгэлцэл, ил тод байдал ба нээлттэй байдал тогтвортой ирээдүйг хангахад чухал үүрэгтэйг хүлээн зөвшөөрсөн. Энд олон нийт болон хувийн секторын хамтын ажиллагаа, хамтарсан үүрэг хариуцлагын чухлыг бас онцолсон байна.

Монголд ТХЗ-уудыг хангахад гарч буй ахиц дэвшлүүдийг үнэлэх үед 4 ТББ ахиц хөгжлийг муубайгааг эгждүгнэсэн (1 нь тодорхойлоогүй). Тэд тусгайлан Эрүүл мэндийг дэмжих (#3), Ядуурлыг устгах (#1), Тэгш бус байдлыг бууруулах (#10), Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх, болон Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох (#8)

зэрэг зорилтууд дээр шүүмжлэлтэй байж ахиц гарахгүй байгааг дурдсан бөгөөд, жендерын эрх тэгш байдлыг хангах (#5) тал дээр зэрэг зүйлс байгааг хэлсэн (#5). Ядуурлыг устгах (#1) ба инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх (#9) зорилтууд нь Монголд хамгийн хамаатай зорилтууд гэж ТББ–ууд тодорхойлсон юм. ТХЗ–уудыг хангахад Монголын компаниудын үүргийг асуухад 2 оролцогч гүйцэтгэж буй үүргийг тааруухан, 2 нь дундаж гэсэн байр суурьтай байсан. Тогтвортой хөгжлийн хувьд Монголын компаниудын бизнесийн үр дүнгүүдэд ямар бизнесийн үйл ажиллагаанууд хамгийн сайн хувь нэмрээ оруулах талаар асуухад ТББ–ууд нэр хүндийг өсгөх, тогтвортой бизнес, хэрэглэгчийн сэтгэл ханамж ба нээлттэй байдал зэргийг дурдсан байна. Нийт оролцогчид “шинэ хамтын ажиллагаа ба түншлэлийг эхлүүлэх боломж”, бас “итгэлцэл, ялангуяа шинэ үеийнхний дунд итгэлцэлийг бий болгох” нь ТХЗ–уудад компаниуд өөрсдийн хувь нэмрээ оруулахад хүргэж буй гол шалтгаанууд гэж онцолсон байна. ТХЗ–уудад амжилт гаргахад компаниудын зүгээс оруулж болох тодорхой хувь нэмрүүдийг тодруулахад шинж төрлийн Олон Нийт–Хувийн секторын түншлэлийн хэлбэр дээр ажиллах, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг бууруулах зорилтуудыг дэвшүүлэх, хэрэгжүүлэх, ТХЗ–уудтай уялдах бүтээгдхүүн үйлчилгээнүүд гаргах, мөн ТХЗ–уудыг тогтвортой байдлын стратеги ба зорилтуудыг төлөвлөхөд чиг шугам болгон ашиглах зэрэг үйл ажлуудыг олонх нь тодорхойлсон байна.

4.5. Судалгаа – Бизнесийн Холбоодын байр суурь

Судалгааг өдөр тутмын бизнесээс бие даасан бизнесийн өнцгөөс нь харж, баяжуулахын тулд 5–н Бизнесийн Холбооноос асуулга авсан бөгөөд эдгээр холбоод нь

салбар салбараас төлөөлөлтэй юм.

Бүх асуулгад оролцогчид КНХ/тогтвортой бизнесийн ойлголттой танил гэж хариулсан бөгөөд дийлэнх нь ТХЗ–уудын тухай сонссон гэсэн юм. Гэхдээ эдгээр зорилтуудын тухайд илүү мэдээлэл аваагүй гэсэн ба 3 төлөөлөгч засгийн газрын зүгээс ийм мэдээлэл ба мэдлэгийг тэдэнтэй хуваалцаагүй гэсэн байна. Тэдний 3 нь КНХ/тогтвортой бизнесийн түвшинг Монголд нааштайгаар өөрчлөгдөж байгаа гэсэн бол 2 нь нөхцөл байдал тааруу байгаа гэж дүгнэсэн. Мэдлэг, туршлага дутуу, сэдэл дутуу, сөрөг сэтгэлзүйн хандлага, бас төрийн хэт оролцоо, мөн олон нийтэд мэдээлэл дутуу байгаа нь Монголд гүйцэтгэл хязгаарлагдмал байгаагийн шалтгаанууд болж байгаа гэж тэд тайлбарласан. Бүх ярилцлага өгөгчдийн хэлснээр КНХ/хариуцлагатай бизнес нь маш чухал бөгөөд одоогийн хууль эрх зүйн орчин сайжрах шаардлагатай, мөн дэмжих, урамшуулах механизм, тэр дотроо жижиг дунд бизнес болон шинэ бизнесүүдийн хувьд нэн чухал байгаа юм. Эерэг нөлөөллүүд нь бизнест ч, бас нийгэмд ч, ялангуяа эмзэг бүлгийн хүмүүст хэрэгтэй байгааг илэрхийлсэн. Монголын нөхцөл байдлыг сайжруулахад бүхий л хамаарагч талууд, тэр дундаа хэрэглэгчид ба олон нийтийн үүрэг нэн чухал гэж оролцогчид онцолсон. Гэхдээ ТББ–уудын өгсөн хариулттай адилаар хэрэглэгчид ба олон нийт өөрсдийн үүргийг хангалттай гүйцэтгэхгүй байгааг хэлээд ирээдүйд ч хэрэглэгчдийн гүйцэтгэх үүрэг хүчтэй болно гэдэгт эргэлзээтэй хандаж байгаагаа илэрхийлсэн байна. Бусад хамаарагч талуудтай адилаар хамаарагч талуудын хооронд хамтын ажиллагаа маш хэрэгтэй бөгөөд хариуцлагатай бизнесийг цаашид шинэ түвшинд гаргахад хамтарсан, үүрэг хариуцлагуудаа хуваалцаж ухамсартай үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх шаардлагатай

байна гэж тэд үзэж байна. ТХ-ын 17-н зорилтуудын бие даасан биелэлтүүдийн тухай тодруулахад Бизнесийн Холбоод бүхэлдээ гүйцэтгэл удаан, ахицгүй байгаа гэж үзэж байгаагаа илэрхийлсэн боловч Жендерын эрх тэгш байдлыг хангах (#5), Эдийн засгийн өсөлт ба баталгаат ажлын байрыг бий болгох (#8), Тэгш бус байдлыг бууруулах (#10) ба Энх тайван шударга ёсыг цогцлоох (#16) зэрэг зорилтууд дээр боломжууд байгаа гэж хариулсан юм. (#16). Эрүүл мэндийг дэмжих (#3), Чанартай боловсролыг дэмжих (#4), Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах (#6) болон Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл (#12) зэрэг зорилтууд нь Монголд хамгийн чухал, нэн уялдаатай зорилтууд гэж Бизнесийн Холбоод үзсэн байна. Бусадтай адилаар 5 төлөөлөл бүгдээрээ зорилтуудыг хангахад хамаарагч талуудын хамтран хариуцаж гүйцэтгэх явдал нэн чухал гэсэн юм. Компанийн түвшинд Эрүүл мэндийг дэмжих (#3), Чанартай боловсролыг дэмжих (#4), Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох (#8), мөн Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл (#12) зорилтууд нь хамгийн чухал зорилтууд гэж төлөөллүүд үзэж байна. Холбоод одоогийн гишүүн компаниудын ТХЗ-уудад оруулж буй ерөнхий хувь нэмрүүдийн тухайд итгэлтэй бус байсан бөгөөд харин бие даасан зорилтууд тэр дотроо Ядуурлыг устгах (#2), Чанартай боловсролыг дэмжих (#4), Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох (#8), бас Тэгш бус байдлыг бууруулах (#10) зорилтуудын хувьд хувь нэмэр зэрэг байгаа гэдэгт итгэлтэй байна гэсэн юм. ТХЗ-уудад компаниуд яагаад хувь нэмэр оруулж байгаа, бас болохыг асуухад бүх 5 оролцогч боломжит нэр хүндийн үр ашгийг дурьдсан юм. Мөн тогтвортой байдлын стратегиуд дээрээ төвлөрөх, нийгмийн хэрэгцээтэй бизнесийн суурь үйл

ажиллагаагаа уялдуулах, шинэ түншлэлийг бий болгох боломж болон шинэ зах зээлд гарах зэрэг шалтгаануудыг мөн нэмж дурьдсан юм. ТХЗ-уудыг хангахад компаниудын оруулж болох тодорхой хувь нэмрүүдийг тодруулахад ТХЗ-уудтай уялдаа бүхий бүтээгдхүүн үйлчилгээг хөгжүүлэх, Зорилтуудыг чиг шугам болгон тогтвортой байдлын стратеги, төлөвлөгөөгөө дэвшүүлэх, шинэ төрлийн Олон Нийт-Хувийн секторын түншлэлийг бий болгох, байгаль орчин ба нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг бууруулах зорилтуудыг боловсруулах, дэмжлэг болж чадах бодлого, хууль эрх зүйн актуудыг дэмжих, хамгаалах, мөн шийдлүүдийг санхүүжүүлэх зэрэг үйл ажиллагаануудыг тодорхойлсон юм.

Бизнесүүд болон ТББ-уудын өгсөн хариултуудтай адилаар санхүүгийн урамшууллууд болон татвараас чөлөөлөх зэрэг, мөн компанийн зүтгэлийг олон нийтийн зүгээс танин мэдэж дэмжих нь маш нэмэртэй гэж Холбоодын төлөөллүүд хэлсэн юм. Илүү тодруулбал тодорхой хувь зорилтуудад дорвитой хувь нэмэр оруулахын тулд Монголын Засгийн газраас маш тодорхой зорилго, чиглэлүүдийг компаниудад гаргаж өгөх нь маш чухал гэсэн юм. Итгэлцлийн тухайд асуухад 2 төлөөлөгч төрийн засаг захиргаа манлайлал болж нээлттэй байдал, ил тод байдлыг сайжруулах үүрэгтэй гэж үзсэн.

Компаниудын илэрхийлсэн эзэлүүд тодорхой байдлаар Бизнесийн Холбоодын төлөөллүүд ажилтнуудын үүрэг тогтвортой бизнесийг хангахад чухал гэдгийг дурдаад компаниуд тэднийг сургаж, бас дэмжих үүрэгтэй, мөн өөрсдийн ажиллаж буй нийгэмдээ буцааж өгөх нь компаниудын үүрэг гэсэн юм.

4.6. Дүгнэлт

Үр дүнгээс харахад компаниуд КНХ ба ТХЗ–уудын бий болгох нэмэлт үнэ цэнүүдийг сайн ойлгож байгаа бөгөөд тэдний олонх нь илүү хариуцлагатай бизнес хийхэд бэлэн байна. Гэхдээ Монголын бизнесийн ертөнц, хууль эрх зүй, улс төрийн орчин, мөн нийт Монголын хүн амын зүгээс хариуцлагатай бизнесийн үйлдлүүдийг сайн дэмждэггүй нь компанийг илүү хичээл зүтгэл

гаргахад нь хязгаарладаг байна. Тиймээс судалгааг дүгнэвэл Монгол дахь ТХЗ–уудын ирээдүй нь Дэлхийн Зорилтуудаас гарах үр өгөөжийг хүртэж саад бэрхшээлүүдийг шийдэхэд бизнес, төр захиргаа ба иргэний нийгмийн талуудын хоорондын гүн гүнзгий, ил тод, урт хугацааны хамтын ажиллагаанаас, бас үүнээс дутахгүйгээр ТХЗ–уудыг амжилтын түүх болгоход хувь хамаарагч тал бүрийн оруулах үүрэг хариуцлагаас хүчтэй хамаарахаар байна. Итгэлцэл бүхий хамтарсан яриа хэлцэлүүд Дэлхийн Зорилтуудыг үйл хэрэг болгоход түлхүүр хүчин зүйл болох ба судалгааны дүнгээс харахад ТХЗ–ууд нь өмнөх оролдлогуудаасаа аялгаатай, ирээдүйтэй санаачлага гэж олон компаниуд үзэж байгаа бөгөөд тиймээс хувь нэмрээ оруулахад бэлэн байгаагаа илэрхийлсэн юм.

Нэгтгэл ба Зөвлөмжүүд

🕒 Бүхэлдээ КНХ/ТХЗ–ууд нь санхүүгийн болон санхүүгийн бус хүчтэй сэдэл урамшууллыг компаниудад бий болгож байна. Гэхдээ энд онгорхой асуултууд их байгаа, учир нь Дэлхийн Зорилтуудыг улс орны хэмжээнд хэрэгжүүлэхэд тодорхойгүй зүйлс олон байгаа юм. Иймээс компаниуд Зорилтуудыг сайн таньж мэдээд, тодорхойлсныхоо дараа уялдах зорилт зорилгуудыг дэвшүүлэх хэрэгтэй байгаа бөгөөд мөн хамаарагч

талуудтай зохистойгоор харилцах арга замыг олох шаардлагатай байна. Улс төр, бизнес ба иргэний нийгмийнхэн мэдлэг мэдээлэл солилцох, арга барилуудаа хуваалцах, хамтарч ажиллах нь нэн чухал байна.

🕒 Хамаарагч талуудын оролцоо, ялангуяа компаниуд үйл ажиллагаагаа явуулдаг нийгмийн бүлгүүдийн оролцоо улам ач холбогдолтой болсоор байна.

🕒 Итгэлцлийг бий болгоход харилцаа холбоо, яриа хэлцэл ба манлайлал нь суурь хүчин зүйлүүд болно. Дэлхий нийтийн хандлагыг харахад бизнес болон улс төрд итгэх итгэл буурсаар байгаа тул компаниуд энэ хандлагыг эргүүлэх арга замуудыг эрэлхийлэх ёстой. Үүний нэг чухал алхам бол хамаарагч тал бүр өөрсдийн гүйцэтгэх үүрэг, бусдынхаа боломж хязгаарыг ойлгож мэдсэнээр үүнийхээ дагуу үүрэг хариуцлагуудаа тодорхойлох явдал юм.

🕒 Ажилчин ажилтнууд ирээдүйд илүү үүрэг гүйцэтгэх бөгөөд компанийн тогтвортой амжилтанд шийдвэрлэх үүрэгтэй оролцоно. Компаниуд шилдэг боловсон хүчинг өөртөө татах, нийт ажилчид, тэр дотроо залуу боловсон хүчний эргэлтийг бууруулахын тулд тэдний оролцоонд хөрөнгө оруулах хэрэгтэй юм.

🕒 Ирээдүйд компанийн бизнесийн үйл ажиллагаанд хэрэглэгчид ба олон нийтийн гүйцэтгэх үүрэг өссөөр байх болно. Үүний зэрэгцээ Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл (Goal #12) дэлхий нийтийн хэмжээнд хамгийн ахиц дэвшил багатай зорилт байсаар байна.

Дэлхий нийтийн болон Монголд хийсэн судалгаануудын үр дүнд дараах **үндсэн дүгнэлт ба зөвлөмжүүдийг** гаргаж болохоор байна. Үүнд:

🕒 Компаниуд, улс төр, иргэний нийгэм ба олон нийт бүхэлдээ КНХ/хариуцлагатай бизнес ба тогтвортой байдал, мөн уялдах

үйл ажиллагаануудыг **бизнесийн гол хүчин зүйл, элемент** гэж үзэх ёстой.

⌚ Хамаарагч талуудын дунд **мэдлэг мэдээлэл солилцох, ахиц дэвшил болон саад бэрхшээлүүдийн тухай яриа хэлцлүүдийг** тогтмол хийж байх үйл явцыг системтэйгээр зохион байгуулалтанд оруулж үүрэг хариуцлагуудыг тодорхойлох ёстой.

⌚ Компаниуд өөрсдийн **боловсон хүчнийг сургаж боловсруулан, эрх мэдлийг олгож** илүү хариуцлагатай, тогтвортой бизнесийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бизнесийн шийдэл ба арга замуудыг олох, тодорхойлоход тэднийг түлхүү оролцуулж байх ёстой юм. Энэ нь Чанартай боловсролыг дэмжих (Goal #4) зорилт нь Монголд маш чухал гэсэн судалгааны үр дүнтэй шууд уялдаж чадна.

⌚ Компаниуд өөрсдийн ажиллаж буй байгаль орчин ба нийгэмдээ үзүүлж байгаа **зерэг болон сөрөг үр дагавар, нөлөөллүүддээ илүү анхаарах хандуулах** шаардлагатай байна. Компани өөрийн хариуцлагын гүйцэтгэлээ хэрхэн үнэлж байгаа болон бусад талууд энэ гүйцэтгэлийг хэрхэн үнэлж байгаагийн хооронд зөрүү гарснаар тал талд үл итгэлцэл, сэтгэлд хүрэхгүй байх явдал гарч болохыг ямагт анзаарч байх ёстой юм.

⌚ Компаниуд болон бусад бүх хамаарагч талууд хариуцлагатай зан төлөв ба харилцаа холбоо аль алины хувьд **жишиг, үлгэр жишээ** болох ёстой. Тэд ямагт, нээлттэйгээр өөрсдийн үүрэг хариуцлагуудаа илэрхийлж бусдын хичээл зүтгэлийг хүлээн зөвшөөрч, үнэлж байснаар олон нийтийн **сэтгэхүйг** өөрчилж, **олон нийтийн зүгээс хамаарагч талуудын зүтгэлийг илүүтэй үнэлэхэд** хүргэж чадна.

⌚ Компаниуд зөвхөн чанартай бүтээгдхүүн үйлчилгээг хүргэх замаар **хэрэглэгчид ба олон нийттэй итгэлцлийг**

үүсгээд зогсохгүй ил тод нээлттэй байж өөрсдийн бизнесийн үйлдэл үйл ажиллагаа, татвар төлөлт зэрэгтээ найдвартай, итгэлтэй байх ёстой юм. Энэ ч компанийн төлөөллүүдээс судалгаанд Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэлийн (Goal #12) зорилт нь компанийн болон улс орны түвшинд хамгийн чухал зорилтуудын нэг гэж үнэлсэнтэй шууд зохилдож байгаа юм.

⌚ Монголын хамаарагч талууд **хариуцлагатай ба тогтвортой бизнесийн хэлбэр, хэв загвар, үйлдлүүдийг таньж тодорхойлон, хүлээн зөвшөөрч үнэлэх** тал дээр илүү түлхүү ажиллах хэрэгтэй байна. Хичээл зүтгэл бүхий урьд алхаж байгаа компаниудыг урамшуулан сэдэлжүүлж, харин тэдэнд өгсөн урамшуулал нь нийтэд зөв зүйтэйгээр ойлгогдож үнэлэгдэж байх ёстой.

Эцэст нь ярилцлага өгсөн хамаарагч талуудын нэн чухал дүзсэн зүйл бол, компаниуд, улс төрийнхэн ба иргэний нийгмийн бүлгүүд **ил тод, тогтмол, зорилтонд чиглэсэн яриа хэлцэл, харилцаа холбоог өрнүүлдэг соёлыг хэвшүүлэх арга замыг олох ёстой.** Зөвхөн итгэлцэл дээр суурилсан орчинд **нийтлэг ойлголцол ба дэмжлэг туслалцаа** бий болох боломжтой. Компаниуд **зерэг хандлагыг** тогтоож үйл явцыг эхлүүлэхэд хувь нэмрээ оруулахын тулд өөрсдийгөө үйл ажиллагааг тодорхойлогчид, эхлүүлэгчид гэж харах ёстой юм.

ХАВСРАЛТ

А. Ярилцлаганд оролцсон компаниудын жагсаалт

(Том =100+, дунд=19–100, жижиг=5–19, бичил=1–5)

| | Компанийн нэр | Бизнесийн чиглэл | Албан тушаал | Ажиллагсдын тоо |
|----|----------------------------------|---|----------------------------------|-----------------|
| 1 | Гурван гал | Эрүүл мэнд | Гүйцэтгэх захирал | 217 |
| 2 | Монгол шуудан | Шуудангийн үйлчилгээ | Гүйцэтгэх захирал | 912 |
| 3 | Оюу Толгой | Уул уурхай | Менежер | 2500 |
| 4 | Хас Лизинг | Санхүүгийн үйлчилгээ | Гүйцэтгэх захирал | 26 |
| 5 | Атлас Копко | Уул уурхайн | Харилцагчийн үйлчилгээ төлөөлөгч | 70 |
| 6 | ХААН Банк | Банк | Бизнес хөгжлийн менежер | 5000+ |
| 7 | GEM International | Ус ундааны компани | Санхүүгийн болон төслийн менежер | 500 |
| 8 | Batu Construction | Барилга | Ерөнхий менежер | 22 |
| 9 | Алтай Ложистик | Ложистик | Гүйцэтгэх захирал | 300 |
| 10 | Үндэсний хөрөнгө оруулалтын банк | Банк | Аудитор | 187 |
| 11 | Начин Заан | Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ | Дотоод аудитын газрын дарга | 300+ |
| 12 | Airmarket | Үйлчилгээ | Хүний Нөөцийн Менежер | 120 |
| 13 | Эрин Зууч | Үл хөдлөх хөрөнгө | Менежер | 10 |
| 14 | UniGas | Байгалийн цэвэр эрчим хүч | Ахлах Хүний нөөцийн мэргэжилтэн | 160 |
| 15 | Да Хүрээ Трэйд | Авто борлуулалт | Менежер | 60+ |
| 16 | Улаанбаатар буян | Оршуулгын үйлчилгээ | Дэд захирал | 170 |
| 17 | Улаанбаатар хотын банк | Банк | Салбарын захирал | 300-400 |
| 18 | Вагнер Ази | Автомашин | Гүйцэтгэх захирал | 550 |
| 19 | Мишээл Mega Mall | Агуулах, Үзэсгэлэнгийн танхим & ЗГ-ын нэг цэгийн үйлчилгээний Төв | Борлуулалтын менежер | N/A |

| | | | | |
|----|---------------------------------------|------------------------------------|--|-------|
| 20 | УБ Төмөр Замын Олон Улсын Тээвэр Зууч | Ложистик | Удирдах захирал | 53 |
| 21 | Сүү ХК | Сүүн бүтээгдэхүүн | Олон нийттэй харилцах менежер | 400 |
| 22 | IFS | Санхүүгийн үйлчилгээ | Хүний Нөөцийн Менежер | 15+ |
| 23 | MAD | Хөдөө аж ахуй | Гүйцэтгэх захирал | 15 |
| 24 | Дулааны цахилгаан станц 4 | Energy | Гүйцэтгэх захирал | 1492 |
| 25 | Эко Алт | Уул уурхайн | Санхүүгийн захирал | 300 |
| 26 | Шунхлай Групп | менежментийн үйлчилгээний | Хуульч | 17 |
| 27 | Anand Road LLC | Дэд бүтэц | Гүйцэтгэх захирал | 55 |
| 28 | Эрдэнэс Таван Толгой | Уул уурхайн | Бүс Нутгийн Хамтын Ажиллагааны захирал | 630 |
| 29 | Raffles International | Боловсрол | Боловсон хүчин | 21 |
| 30 | SICA LLC | Судалгаа, Зөвлөх үйлчилгээ | Менежер | 16 |
| 31 | Юнитель | Харилцаа холбоо | Хүний нөөцийн захирал | 1000+ |
| 32 | Төрийн Банк | Банк санхүү | Хүний Нөөцийн судалгааны шинжээч | 3550 |
| 33 | Mining National Operator | Уул уурхай | Захирал | 150 |
| 34 | Greentrends | Байгаль Орчны зөвлөх үйлчилгээ | Бизнесийн хөгжлийн захирал | 7 |
| 35 | TESO Corporation | Худалдаа, аж үйлдвэр, барилга | Хүний нөөцийн захирал | 1000+ |
| 36 | Номин Холдинг | Худалдаа, жижиглэн | Худалдан авалтын менежер | 5336 |
| 37 | Petrotrak | Уул уурхай | Гүйцэтгэх захирал | 21 |
| 38 | Edshill | Дизайн, Зөвлөх үйлчилгээ & барилга | Захирал | 26 |
| 39 | MCS, APB | Ус ундаа | ХН-ын захирал | 260 |

| | | | | |
|----|-----------------------|------------------------------------|--|-------|
| 40 | Тэлмэн Групп | Барилга | Ерөнхийлөгч | 116 |
| 41 | Гандирс Групп | Уул уурхайн, аялал жуулчлал | Ерөнхийлөгч | 100 |
| 42 | Далай Буян | Барилга, аж үйлдвэр ба худалдаа | Гүйцэтгэх захирал | 51 |
| 43 | Хаан Даатгал | Даатгал | Санхүүгийн менежер | 25 |
| 44 | APU | Ус ундаа | Стратеги төлөвлөлтийн захирал | 810 |
| 45 | Master Mining Service | Уул уурхай | Захирал | 30 |
| 46 | Uils Road LLC | Барилга | Гүйцэтгэх захирал | 50 |
| 47 | Сүрлэг Хангайн Зам | Уул уурхай | Гүйцэтгэх захирал | 47 |
| 48 | Монос Групп | Эм, эмийн бүтээгдхүүн | Хөрөнгө оруулалт, худалдан авалтын менежер | 1500+ |
| 49 | Капитал Банк | Банк санхүү | Санхүүгийн Хөрөнгийн удирдлагын захирал | 350 |

В. Ярилцлагад оролцсон Бизнесийн Холбоодын жагсаалт

| | Байгууллагын нэр | Албан тушаалтан |
|---|--|-------------------|
| 1 | Монголын Бизнесийн Зөвлөл | Менежер |
| 2 | Монголын Банк бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоо | Гүйцэтгэх захирал |
| 3 | Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт | Гүйцэтгэх захирал |
| 4 | Америкт Төгсөгч Монголчуудын Холбоо | N/A |
| 5 | Улаанбаатар Ротари Клуб | Ерөнхийлөгч |

С. Ярилцлагад оролцсон ТББ-уудын жагсаалт

| | Байгууллагын нэр | Албан тушаалтан |
|---|-----------------------|-------------------------|
| 1 | Хөгжлийн Шийдэл | Гүйцэтгэх захирал |
| 2 | ТББ1- Нэрээ нууцалсан | Бичигдэхгүй |
| 3 | ТББ2- Нэрээ нууцалсан | Бичигдэхгүй |
| 4 | Зориг сан | Хөтөлбөрийн зохицуулагч |
| 5 | UFE | Бичигдэхгүй |